

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-38

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./ 4-38

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны
10 дугаар сарын 24-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 07 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бат-Эрдэнэ, Ж.Баясгалан, Л.Энхнасан;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа;

Тасалсан: Ж.Чинбүрэн.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын ахлах аудитор Ц.Батсүх, Ш.Наран, аудитор Ж.Мөнхбилгүүн, Г.Оюунтөгөлдөр, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, аудитын менежер Ю.Энхтуяа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, мэргэжилтэн Ч.Мөнхшүр, Б.Энхжин, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, мөн хэлтсийн ахлах шинжээч Э.Цолмон, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн шинжээч Ж.Алтантуяа, ахлах мэргэжилтэн В.Содномдаржаа, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Хонгорзул, мөн хэлтсийн мэргэжилтэн Э.Ганпүрэв, Санхүү, даатгалын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг, Тусламж, үйлчилгээ, чанар, төлбөрийн хяналтын газрын дарга Г.Ариунсайхан, Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга Б.Оюунцэцэг, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Гантөмөр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга Б.Батжаргал, мөн яамны Эдийн засаг, санхүү, төсөв хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, Гэр бүлийн бодлогын газрын дарга Н.Баярмаа, Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний хэлтсийн дарга Б.Мөнхзориг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийн дарга С.Рэгзэн, Боловсролын яамны Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын ахлах шинжээч Ц.Отгонмягмар, шинжээч П.Болормаа, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч Э.Адьяасүрэн, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон

гүйцэтгэгч З.Бауыржан, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын Мэдээллийн технологи, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга Н.Оюунчимэг, мөн газрын Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн газрын дарга У.Долгормаа, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Нармандах, мөн газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Батчимэг, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн захирал Б.Бямбадорж, Улсын гуравдугаар төв эмнэлгийн захирал Ц.Төмөр-Очир, Хавдар судлалын үндэсний төвийн захирал Н.Эрдэнэхүү, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Ш.Алтантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх М.Отгон, Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, А.Ариунзаяа, О.Саранчулуун, Ц.Мөнхтуяа, Д.Үүрийнтуяа, М.Нарантуяа-Нара, Д.Ганмаа, Ц.Идэрбат нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийн дарга С.Рэгзэн нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

М.Ганхүлэг: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцын урсгал зардалд багтах Нийгмийн халамжийн сангийн хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний санхүүжилтэд тусгагдсан 21,381.2 сая төгрөгийг 300.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр “Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны зардлын өмгөөлөл хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс зориулалтад нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлж, Сангийн сайд Б.Жавхлан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	6
Бүгд:	16

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаагийн гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2-р хавсралтын бүх төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг

5 хувиар бууруулж, Эрүүл мэндийн сайдын багцын урсгал зардлыг 205.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа үг хэлж, Сангийн сайд Б.Жавхлан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 11
Бүгд: 16
31.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 13 минут үргэлжилж, ирвэл зохих 21 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 76.2 хувийн ирцтэйгээр 14 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Л.ЭНХНАСАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
12 цаг 07 минут.

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

М.Ганхүлэг: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Ирц бүрдсэн учраас бүгдээрээ хуралдаанаа эхлүүлье. Өнөөдрийн хуралдааныг Байнгын хорооны дарга маань бас гадаад томилолттой, Улсын Их Хурлын даргын тушаалаар гадаад томилолттой байгаа учраас Ганхүлэг миний бие бас удирдаад явуулахаар болсон. Тэгээд гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргээд хуралдаанаа эхлүүлье.

Хуралдаанд Аюушийн Ариунзаяа гишүүн хүрэлцэн ирсэн байна. Сархадын Зулпхар, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Сүхбаатарын Эрдэнэбат, Даваасамбуугийн Ганмаа, Цагаанхүүгийн Идэрбат, Отгоны Саранчулуун, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Мягмардашийн Сарнай гишүүд бас хүрэлцэн ирсэн байна. Гадаадад томилолттой 3 гишүүн байгаа юм байна. Б.Бат-Эрдэнэ гишүүн, Ж.Баясгалан гишүүн, Л.Энхнасан гишүүн нар гадаадад томилолттой, өвчтэй Х.Болормаа гишүүн гээд 4 гишүүн үндсэндээ өвчтэй, чөлөөтэй саналаа ирүүлсэн байна. Бусад гишүүд хуралдаан ирсэн байна. Ингээд 52,4 хувийн ирцтэй байгаа тул Байнгын хорооны хуралдааныг эхлүүлье.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025

оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл, ЗГ 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн. Энэ асуудлаар өнөөдөр манай Байнгын хороо хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтой саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудлаа баталъя. Ажлын хэсгийн гишүүдийг оруулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Сангийн сайд хөдөө аж ахуй, Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр бас байгаа байх, наашаа дуудаад, хуралдаан эхэлж байна гээд хэлээрэй. Бусад ажлын хэсгийнхнийг бүгдийг нь оруулчхаарай. Асуудалтай холбогдолтой бусад сайдуудыг бас бүгдийг нь дуудаарай. Нөгөө давхар, давхар бас хурлууд яваад нэг жоохон 2, 3 газар яваад байх шиг байна. Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хороо бас хуралдаж байгаа. Гол нь танилцуулга хийх Жавхлан сайдыг та бүхэн маань дуудаарай. Заяабал даргыг бас дуудах хэрэгтэй болох байх манайхан тийм ээ. Загджав даргыг шүү тийм, буруу хэлсэн байна. Орж ирж байна. Ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг та бүхэндээ танилцуулъя. Сангийн сайд Жавхлан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан, Монгол Улсын Ерөнхий аудитор Загджав, ЭМЯ-ны ТНБД Очирбат, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Самбууням, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Л.Мөнхцацрал, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежерт Ю.Энхтуяа, Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсүх, Санхүү-нийцлийн аудитын

газрын аудитор Ж.Мөнхбилгүүн, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитор Г.Оюунтөгөлдөр гэсэн аудитын бүрэлдэхүүн байна.

Сангийн яамнаас Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Батмөнх дарга байна уу? Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Ганзориг дарга, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга Б.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Н.Баярмаа, Хөдөлмөрийн бодлогын газрын дарга Б.Мөнхзориг, Гэр бүлийн бодлогын газрын Гэр бүл, хүн амын хөгжлийн хэлтсийн дарга М.Цогтбаатар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Бауыржан, Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын ерөнхий газрын Мэдээллийн технологи, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга Н.Оюунчимэг, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хамгааллын ерөнхий газрын Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн газрын дарга У.Долгормаа, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтсийн дарга С.Рэгзэн, ЭМЯ, ЭМЯ-ны Стратеги, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Хонгорзул, ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын Санхүү, даатгалын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг, ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Э.Ганпүрэв, ЭМД-ын ерөнхий газрын даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч М.Нармандах, ЭМД-ын Ерөнхий газрын Бодлогын

төлөвлөлтийн газрын дарга Б.Батчимэг, ЭМЯ-ны Тусламж, үйлчилгээ, чанар, төлбөрийн хяналтын газрын дарга Г.Ариунсайхан, ЭМЯ-ны Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга Б.Оюунцэцэг, ЭМЯ-ны Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Гантөмөр, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн захирал Б.Бямбадорж, Улсын гуравдугаар төв захирал Ц.Төмөр-Очир, ХСҮТ-ийн захирал Н.Эрдэнэхүү, ГССҮТ-ийн захирал Галбадрах, ЭХЭМҮТ-ийн захирал Ш.Алтантуяа.

Эдийн засаг, хөгжлийн яамныхан арай ирээгүй байна уу? Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам Г.Батдорж Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Залуучуудын хөгжлийн бодлого хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Боловсролын яамны бүрэлдэхүүн Боловсролын яамны Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын ахлах шинжээч Ц.Отгонмягмар Боловсролын яамны Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын шинжээч П.Болормаа, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч Я.Адьяасүрэн гэсэн бүрэлдэхүүн хүрэлцэн ирсэн байна. Сүүлд нэмэгдсэн хүмүүсийг очоод тэмдэглээгүй учраас ингээд үлдээлээ.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдолтой Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, өглөөний мэнд хүргэе бүгдэд.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, ЭМД-

ын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг 24 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна. Ирэх 2025 он нь ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарааны бүтэн жил учраас төсвийн бодлогыг бүсчилсэн хөгжилд зайлшгүй шаардлагатай суурь дэд бүтцийг шийдэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдэхэд чиглүүлснээр өмнөх жилүүдээс ялгаатай юм. Энэ шинэ 30 жилийн хөгжлийн суурийг тавих томоохон төслүүдийг эхлүүлэх, төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшлийг дэмжихэд чиглэсэн 25 оны төсөвт нийгмийн бодлогын чиглэл тусгасан онцлог арга хэмжээг дурдвал.

1.Төрийн албан хаагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан 6 хувиар нэмэгдүүлнэ. Монгол Улсын ЗГ-т нийт төрийн албан хаагчдын цалинг 2023 оны 7 дугаар сарын 1-нээс дунджаар 40 хувиар 24 оны 4 дүгээр сарын 1-нээс төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 20 хувиар бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар тус тус нэмэгдүүлсэн. Мөн төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутгийн төрийн захиргаа, төрийн үйлчилгээ болон улс төрийн албан тушаалын албан хаагч сум, тосгонд ажиллаж байгаа бол 40 хувиар, аймгийн төв болон нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа бол 20 хувиар үндсэн цалингаас тус тус тооцож орон нутгийн нэмэгдлийг 24 оны 4 дүгээр сарын 1-нээс олгож байна.

Ирэх 2025 оны төсвийн төсөл 226,2 мянган төрийн албан хаагчдын цалин хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан 6 хувиар нэмэгдүүлэхээр тооцлоо. Тэтгэвэр, тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулан 6 хувиар нэмэгдүүлнэ. Монгол Улсын Их Хурлаас 2023 онд нийгмийн даатгалын багц хуулийг шинэчлэн баталсан бөгөөд эдгээр

хуульд тэтгэврийг жил бүр инфляцтай уялдуулан нэмэгдүүлэх, тэтгэврийг тогтооход баримтлах итгэлцүүрийг жил бүр шинэчлэх зохицуулалт тусгагдсан. Ирэх онд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 510 мянган иргэний тэтгэврийг инфляцтай уялдуулан 6 хувиар нэмэгдүүлж, итгэлцүүр шинэчлэхтэй холбоотой зардлыг тус тус тооцож, 2025 оны төсөвт тусгалаа. Түүнчлэн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоолгох эрх үүсээгүй халамжийн тэтгэвэр авагч иргэдийн тэтгэврийн хэмжээг инфляцтай уялдуулан 6 хувиар нэмэгдүүлэхэд шаардагдах зардлыг мөн тусгасан.

3.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх нийгмийн халамжийг сайжруулна. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн насны онцлог, эрүүл мэндийн байдлаас шалтгаалан тэдний хэрэгцээ эм, тарианы зардал бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн зардалтай харьцуулахад өндөр байдаг тул нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийг хөгжлийн бэрхшээлийн онцлогоос хамаарч ялгаатай тогтоох шаардлагатай байдаг. Иймд байнгын асаргаа шаардлагатай хүүхэдтэй өрхийн орлогын баталгааг сайжруулах үүднээс тэдэнд олгодог амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 2025 онд 6 хувиар нэмэгдүүлэхийн зэрэгцээ хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох тэтгэмжийг уг нэмэгдсэн хэмжээнээс 30 хувиар өсгөхөд шаардагдах зардлыг тусгалаа. Түүнчлэн хараагүй болон хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд үүсдэг хүндрэл бэрхшээлийг арилгах зорилгоор боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын байгууллагуудад дохионы хэлмэж орчуулах үйлчилгээ авах зардлыг төсвийн төсөлд тус тус тусгалаа. Монгол Улсын 2025 оны төсвийн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлснээр төсвийн тэнцвэржүүлсэн орлого 33,9 их наяд төгрөг, суурь зарлага 32 их наяд төгрөг,

нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,9 их наяд төгрөгийн эерэг байхаар байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 25 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 25 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

М.Ганхүлэг: Дараагийн танилцуулгыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. Ажлын хэсэг 4 номерын микрофоныг өгөөрэй.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье. Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хуулийн хугацаанд хийж, гүйцэтгэн аудитын тайлан, дүгнэлтийг Улсын Их Хурал, ЗГ-т хүргүүлсэн болно.

Аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг хянаж, үнэлэхэд

чиглэсэн. Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засаг, нийгмийн тулгамдсан болон хугацаа шаардсан суурь асуудлуудыг шийдвэрлэж эхлэх, бүсчилсэн хөгжлийн цогц реформын эхний шат болон нийслэлийн төвлөрлийг сааруулах том төслүүдийг эхлүүлэх зорилт тавьсан байна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тэнцвэржүүлсэн орлого 33 их наяд 866,7 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35,6 хувь, нийт зарлага 35 их наяд 795,2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37,7 хувь, төсвийн суурь тэнцэл 1 их наяд 909,5 тэрбум төгрөгийн ашигтай, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 930,5 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

ЗГ-аас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдалтай төлөвлөжээ. Гэр бүл, нийгмийн хамгааллын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 4 их наяд 602,1 тэрбум, Эрүүл мэндийн сайд 1 их наяд 854,8 тэрбум, Нийгмийн даатгалын сан 5 их наяд 815,5 тэрбум, ЭМД-ын сан 2 их наяд 216,3 тэрбум, Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2025 оны төсвийн төслийг 2024 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад төвлөрүүлэх орлогын хэмжээ 1 их наяд 649,6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд ЭМД-ын орлогыг 560,8 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн орлогыг 1 их наяд 50,5 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн сайдын харьяа төсөвт байгууллагын өөрийн орлогыг 2,5 тэрбум төгрөгөөр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсөвт байгууллагын өөрийн орлогын хэмжээг 35,5 тэрбум төгрөгөөр, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын орлогыг 0,2 тэрбум төгрөгөөр, бусад орлогыг 0,5

тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээг 2024 оны тодотгосон төсвөөс 1 их наяд 903,9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын урсгал зардлын төсвийг 584,1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 4 их наяд 501,8 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 17,5 тэрбум төгрөг, байр ашиглахтай холбоотой зардлыг 7,5 тэрбум төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 2,1 тэрбум төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлын 1,5 тэрбум төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамжийг 64,7 тэрбум төгрөг, төрийн өмчит байгууллагад олгох татаасыг 278,2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна. Хөрөнгө оруулалтын төсвийг 21 төсөл, арга хэмжээнд нийт 54,3 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 3 төсөл, арга хэмжээнд 13,7 тэрбум төгрөгийг гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Эрүүл мэндийн сайдын урсгал зардлын төсвийг 284,1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 1 их наяд 660,1 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 8,8 тэрбум төгрөг, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 1 тэрбум төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамжийг 16,7 тэрбум төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардлыг 19,3 тэрбум төгрөг, ЗГ-ын урсгал шилжүүлгийг 248,9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна. Хөрөнгө оруулалтын төсвийг 39 төсөл, арга хэмжээ нийт 194,6 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 12 төсөл, арга хэмжээний хэмжээнд 152,7 тэрбум төгрөгийг гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн урсгал зардлын төсвийг 694,3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 5 их наяд 882,7 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн урсгал зардлын төсвийг 380,7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 2 их наяд 293,9 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна. Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл, төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан шалгуурыг хангасан гэж дүгнэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

М.Ганхүлэг: Баярлалаа. Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Байнгын хорооны гишүүдэд бас хүргүүлсэн байгаа. Хууль санаачлагчдаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүд дэлгэцийн урд талынхаа кнопыг дараад нэрсээ өгье. Саранчулуун, Нарантуяа-Нара гишүүнээр тасаллаа. Ирцээрээ дээр болчхож байгаа байх. Ингээд асуултыг Эрдэнэбат гишүүнээс эхлүүлье.

С.Эрдэнэбат: 1 дүгээрт цалин хөлсний хувьд энэ төсвийг ярилцахад бас нийгмийн бүлгүүдтэйгээ сайн бүрэн хэмжээнд ярьж чадаагүйгээс болоод санал, шаардлагууд их ирээд байна. Ялангуяа энэ манай төрийн албан хаагчид төсвийн байгууллагуудын гол цөм болсон боловсрол, эрүүл мэндийн салбар. Тийм учраас яах вэ 6 хувь гэдгээс инфляцын түвшин гэж байгаа. Энэнээсээ дээшээ нэмэх боломж байна уу 1 дүгээрт үндсэн цалин.

2 дугаарт эрүүл мэндийн салбарт гэхэд гүйцэтгэлийн санхүүжилт гэчихсэн мөртөө цалинг нь ингээд дээш нь өсгөх боломжгүйгээр бариад тавьчихсан. Энэ нь өөрөө эргээд нөгөө гүйцэтгэлийн гэдэг тэр мөн чанараасаа алдагдаад байгаа.

Тийм учраас энэ эрүүл мэндийн салбарт гүйцэтгэл гэж байгаа бол хийсэн ажил үүрэгтэй нь уялдуулаад эрүүл мэндийн олон бас салбар ажилчидтай уулзаж байхад дийлэнх нь бас энэ цалин хөлсөндөө бас сэтгэл дундуур байна гэдэг ийм байр суурийг илэрхийлээд, санал шаардлага болгоод, жагсаал цуглаан хийгээд ийм болоод байгаа юм. Тэгэхээр энэ тал дээрээ эрүүл мэндийн зарим байгууллагууд маань цалин хөлсний хувьд ч гэсэн бас хүндэрч байна гэдэг саналууд их ирүүлээд байгаа юм. Тэгэхээр би энд байгаа эмнэлгийн удирдлагууд маань зовлон, жаргалыг нь бас мэднэ. Сайд ч бас мэдэж байгаа байх. 200 орчим тэрбум төгрөгийн алдагдалтай байна өглөгтэй байна гээд байгаа юм. Хийчихсэн юмных нь гүйцэтгэлийнх нь мөнгийг өгч чадахгүй байна, сан дийлэхгүй байна гээд нэг ийм асуудал байгаа.

Хоёрдугаарх нь боловсролын салбар дээр гүйцэтгэлийн үнэлгээ гээд бас яах вэ ерөнхийдөө үнэлгээний хувьд бол тогтолцоо бол байгаа. Тэрийг нь бас тодорхой хэмжээнд нь зохицуулалтыг нь хийгээд болж өгвөл эргээд тэр хүмүүсийн цалин хөлс орлогыг нь дээш нь нэмэгдүүлэх, гүйцэтгэлийн үнэлгээг нь үндсэн цалин руу нь тодорхой хэмжээгээр нь шилжүүлэх эд нар гэх мэтчилэн ийм байдлаар цалин хөлсний тэр гэрээ хэлэлцээрт нь заасан байдлаар нэмэгдүүлэх боломж байна уу гэдгийг бас асуумаар байна. Эрүүл мэндийн даатгалын сан дээр техникийн хорооны зардал гээд тавьсан, тэрийг хасаад оруулаад ирчихсэн байгаад л байх шиг байна лээ. Энэ техникийн хороо ажиллахгүйгээр цаашаа энэ эрүүл мэндийн өртөг үйлчилгээ чинь ерөөсөө олигтой явахгүй. Тийм учраас энэ зардлыг тавьсан уу?

2-т, 3 дугаарт ЭМД-ын сангийн чөлөөт үлдэгдэлд хүү тооцох асуудлыг Сангийн яаманд би бас тавьж байсан. Энэ асуудлыг нь яагаад хүү тооцдоггүй юм бэ? Уг нь бол энэ чинь даатгуулагчдын

мөнгө учраас хүү тооцох ёстой. Энэ тал дээр тусгасан уу гэж би хэлмээр байна.

Дараагийн нэг асуудал хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй гээд миний байнга л ярьдаг зүйл л дээ. Манай төрийн байгууллагууд маань ерөөсөө энэ зардлыг тавьж өгдөггүй. Тухайн хуульдаа байж байдаг нийт зардлынхаа 0,5. Гэтэл хувийн хэвшил болон бусад байгууллагууд 1,5 гээд бид нар хуулиар үүрэг өгчихсөн мөртөө төрийн байгууллагууддаа 0,5 тавиад тэрийгээ өгдөггүй. Тийм учраас энэ осол аваар эндэгдэл аливаа энэ орчны аюулгүй байдлын асуудал дээр бид нар төсвийн бодлогын хувьд, нийгмийн бодлогын хувьд анхаарахгүй байна. Тэгэхээр ерөөсөө энэ хэдэн төгрөг яаж тавигдсан юм бэ гэдгийг асуумаар байна.

М.Ганхүлэг: Дэгийн тухай хуулиар асуулт 3 минут байгаа. Тэгээд олон салбарын асуудал ярьж байгаа учраас гишүүд маань маш сайн тоймлоод давхардуулахгүй асуугаад явах нь зөв байх. Сангийн сайдаас эхэлж хариулах уу? Сангийн сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Баярлалаа. Гишүүний асуултад хариулъя. Тэр Төрийн албаны хууль бусад хууль тогтоомж ялангуяа Нийгмийн даатгалын тухай хуульд орсон өөрчлөлтөөр ирэх жилээс эхлээд ер нь жил бүр үнийн өсөлттэй уялдуулж, цалингийн суурь хэмжээг болон тэтгэврийн суурь хэмжээ дээр нэмэгдэл тооцож байх ийм хуулийн заалттай болсон. Гишүүнээ тэгээд ийм шүү. Энэ жил төсөв 9 сарын 1-нд өргөн барьсан. Мөнгөний бодлого 10 сарын 1-нд өргөн барьдаг, сарын дараа. Биднийг өргөн барихад мөнгөний бодлогын зорилтот инфляцын түвшин 6 хувь, 6 хувь +,-2 гэсэн үг. Ийм депозон дотор байна. Төрийн бодлого 6 хувь руугаа чиглэнэ гэж байгаа юм. Нэгэнт мөнгөний бодлого нь ийм байгаа учраас төсвийн бодлогоор бид энийг зөвшөөрч дэмжиж явна. Тийм учраас 6 хувь гэж орж ирж байгаа юм. 8 юм уу гэх гээд ингэх юм нөгөө мөнгөний

бодлогынхоо зорилтот түвшнийг үгүйсгээд, мөнгөний бодлого нэг тийшээ, төсвийн бодлого нөгөө тийшээ жинхэнэ нөгөө энэ 2 бодлого чинь нийцдэггүй ийм томъёолол руугаа орно.

Гэтэл ямар өөрчлөлт орж ирж байна вэ гэхээр 10 сарын 1-нд өргөн барьсан мөнгөний бодлогоор нөгөө 6 хувийн голч маань 5 хувь болсон байгаа шүү. 5 хувь дээр +,-2 буюу 3-аас 7-гийн депозон дотор. Өөрөөр хэлбэл одоо бид нар энэ өргөн барьсан 6 хувийгаа бүр 5 хувь болгох ийм нөхцөл байдал үүсэж байна гэсэн үг. Ийм бодлогын ойлголттой байна.

ЭМД-ын санд хүү тооцох уу гэж яах юм. Яаж хүү тооцох вэ дээ. ЭМД-ын сангийнх чинь дөнгөж 30 хувь нь шимтгэлээр бүрддэг юм шүү дээ. Үлдсэн цаад 70 хувийг нь татвар төлөгчдийн мөнгөөр төсвөөс зузаатгал хийдэг. Төсвөөс зузаатгал хийгээд, хийсэн зузаатгал дээрээ дахиад хүү тооцоод явна гэж юу байх вэ дээ. Чөлөөт үлдэгдэл дээр ер нь хүү ашиг өгөөж тооцохоосоо илүү урдах гашуун түүхүүдээ харах юм найдвартай хадгалах нь чухал байдаг. Тийм учраас аль болох Төрийн санд байлгах, Монголбанкн дээр байршуулах ийм найдвартай энийг хамгаалах төлбөрийн чадвар нь 100 хувь хангах ийм нөхцөл зорилготойгоор суурь шаардлага нь цаашидаа ч гэсэн явна.

М.Ганхүлэг: Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбогдолтой асуулт асуусан. Энх-Амгалан сайдын микрофоныг өгье. 3 минут байх.

Л.Энх-Амгалан: Нөгөө нэмэлт үндсэн хариулт учраас 3 минутаар тийм. Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Эрдэнэбат гишүүн Үйлдвэрчний холбооны ерөнхийлөгч ингээд үйлдвэрчний 2 үйлдвэрчний эвлэлийн ерөнхийлөгчид маань бас ингээд ороод ирчихсэн учраас бол энэ удаагийн Их Хурал дээр нэлээн бас энэ Монгол Улсын төрийн албан хаагчдын цалин хөлсний тогтолцоо, нийгмийн

баталгааны тогтолцоо дээр бол нэлээн тийм реформ шинэчлэл хийсэн жил байх болов уу гэж бид нар харж байгаа юм.

Тэгэхээр би бас Улсын Их Хурлын гишүүдээсээ хүсэхэд цөмөөрөө 25 оны төсвийг бид нар ярьж байгаа. Тэгэхдээ нэг оны төсвөөр бид нар энэ олон жил хуримтлагдсан байгаа энэ цалин хөлсний тогтолцоо, энэ гүйцэтгэлийн үнэлгээний асуудлыг нэг оны төсвөөр цөмөөрөө шийднэ гэж байхгүй. Тийм учраас ингээд нэгэнт эвслийн ЗГ гарсан, ингээд олон нийгмийн олон төлөөлөл орж ирсэн энэ удаагийн Их Хурал бол яг Монгол Улсад цаашидаа энэ төрийн албаны албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааны тогтолцооны шинэчлэлийг цөмөөрөө ярья. Тогтолцооны шинэчлэл хийгээрэй. Тэрнээс биш 25 оны.../минут дуусав/

М.Ганхүлэг: Энх-Амгалан сайдад нэмэлт минут өгье. Сая 3-аар явсан.

Л.Энх-Амгалан: Өгч болохгүй юу? Биш 1 минут байна, 1-ээр явчихлаа. Тэгэхээр уг нь ярьж байгаа асуултууд нь их том асуултууд асуугаад, хариулт нь нэг минутаар яваад байвал тэгээд хариулт авч чадахгүй л дээ. Тэгэхээр бид нар энэ удаагийнхаа өөрчлөлтөөр энэ төрийн албан хаагчдын цалин хөлсний тогтолцооныхоо шинэчлэлийг цөмөөрөө хийх нь их зайлиггүй шаардлага байгаад байгаа юм. Тэгэхээр яг үндсэндээ бол юу гэдэг юм нийт төрийн албан хаагчдын чинь 225 мянган төрийн албан хаагчдын чинь бараг 93 хувь нь дандаа гүйцэтгэлийн урамшуулал авдаг юм байна лээ 93 хувь нь. Гүйцэтгэл тооцдоггүй, гүйцэтгэлийн урамшуулал авдаг хавтгайрчихсан гэсэн үг байхгүй юу. Дахиад нэг гүйцэтгэл хавтгайрчихсан гэсэн үг. Тийм учраас цалин хөлс нэмье гэдэг бодлоготой бол бид нар бүгдээрээ байгаа. Цалин хөлс нэмэхгүй гэдэг өнөөдөр нэг ч Их Хурлын гишүүн, нэг ч ЗГ-ын гишүүн байхгүй болов уу. Хамгийн гол нь цалин хөлсний бодлого бол цаашидаа бүтээмж, гүйцэтгэл дээр суурилсан энэ

тогтолцоо байх ёстой. Бусад улсууд ч тийм байдаг. Хамгийн өндөр гүйцэтгэлтэй, хамгийн өндөр бүтээмжтэй улсууд л өндөр цалин авч байх тогтолцоонд бид нар шилжсэн шүү дээ. Тийм учраас энэ тогтолцооны шинэчлэл рүүгээ бид нар энэ.../минут дуусав/

М.Ганхүлэг: Дахиад нэг минут авах боломж байгаа. Энх-Амгалан сайдын микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Энэ хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудал Монгол Улсад маш их том харанга цохихоор ийм нөхцөл байдалд бид нар орчихсон байна. Жил бүхэн өнөөдөр энэ хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл хангагдаагүйн улмаас 400-аас 500 залуучууд маань амь насаа алдаж байгаа ийм тоо гарчхаад байж байна шүү дээ. Тийм учраас цаашид бид нар энэ Монгол Улсын ХАБ-ын тогтолцооны асуудлуудыг томоохон хэмжээнд харах ийм шаардлага байгаа юм. Харин би Сангийн яам бол бас маш их тийм юутай ажиллаж байгаа санал санаачилгатай ажиллаж байгаа. Сангийн яамны ТНБД энэ олон жил хэрэгждэггүй энэ Ахмадын сан, Хөдөлмөр эрхлэлтийн энэ ХАБ-ын зардлыг тэр байгууллагын нөгөө урсгал зардалд нь оруулж, сан байгуулж оруулж байх энэ тогтолцоогоо хангаж ажилла гэдэг зүйл дээр нэлээн чиглэлүүд өгч байгаа сүүлийн үед. Ингээд ирэх 25 онд манай Ариунзаяа сайд маань энэ Төсвийн байнгын хороон дээр санаачилна гэж ойлгоод байгаа шүү дээ тийм үү? Аудиттай бид нар нийцлийн аудитын төлөвлөгөөнд оруулаад энэ Ахмадын сан, энэ ХАБ-ын зардлуудыг яагаад энэ аж ахуй нэгжүүд энэ зардалдаа оруулдаггүй байгаа юм бэ? Энэний журмуудыг өөрчлөх.../минут дуусав/

М.Ганхүлэг: Тодруулах юм уу? Эрүүл мэндийн сайдын микрофоныг өгье.

Т.Мөнхсайхан: Энэ гүйцэтгэлийн санхүүжилт 20 оноос шилжсэнээс 21 онд

шилжсэнээс хойш нэлээн эерэг үзүүлэлтүүд нэлээн гарсан. Гэхдээ бид нар даатгалын сангаас санхүүжилтийг нь олгохдоо эмнэлгүүдэд гүйцэтгэлээр нь олгоод байдаг. Эмнэлгүүд маань харин цалин хөлс урамшуулаа олгохдоо гүйцэтгэлээрээ сайн тооцож чадахгүй байгаа. Тэгэхээр ирэх онд бид нар эмнэлгүүд эмнэлгийн ажилчдаа гүйцэтгэлээр нь цалин урамшууллыг нь тооцох энэ зүйл дээрээ онцгой анхаарал хандуулж байгаа. Одоогийн байдлаар бол Сангийн яамнаас бол жишээ нь ингээд цалин хөлсний урамшуулал, нэмэгдэл урамшууллыг ингээд 20 хувиас дээш гаргахгүй байх хязгаар тавьчхаад байгаа юм. Энэ нь юутай холбоотой вэ гэхээр яг бодит ажлыг нь үнэлэхгүйгээр илүү их тийм урамшууллуудыг олгоод байгаа асуудал гараад байгаа учраас энэ дээр ийм хязгаар тавьчихсан байж байгаа.

Тэгэхээр ирэх жил энэ гүйцэтгэлийнхээ үнэлгээг оновчтой болгоод, Сангийн яамнаас энэ хязгаарыг авхуулах асуудлыг бас Сангийн сайдтай ярилцсан байж байгаа. Энэ техникийн хорооны хувьд бол техникийн хороо нь.../минут дуусав/

М.Ганхүлэг: Шинэ бас хуулиараа юу болчхоод байдаг, нэмэлт дуусгах уу та? Мөнхсайхан сайдын микрофоныг дахиад өгье.

Т.Мөнхсайхан: Энэ техникийн хороо нь бас өмнөх сайдын үед ер нь байгуулагдчихсан. Одоо гэхдээ энэ зардал мөнгө нь энэ техникийн хороо нь 9 гишүүнтэй байна гээд. Энэ 9 гишүүн нь бас цалин мөнгөнийх нь асуудал яригдаад байгаа. Энийг бол бас Сангийн яам руу бид нар энэ техникийн хорооны зардлыг нь гаргах шаардлагатай байна гэдэг энэ тооцоо тооцооллуудаа бол Сангийн яам руу өгсөн байгаа. Тэгэхээр ирэх оны төсөв дээр энэ техникийн хорооны ажиллах зардлыг нь тусгаад өгчихвөл Техникийн хороо маань ямар ч асуудалгүй үйл ажиллагаагаа явуулах боломжтой.

Гэхдээ энэ техникийн хороодын гишүүдийнхээ бас ашиг сонирхлынх нь энэ мэдүүлгийг нэлээн сайн харж байж, энэ дээр бас заавар зөвлөмж авч байж явахгүй бол эргээд энэ техникийн хороо нь бас ингээд ажил явдаггүй юм уу, ингээд ашиг сонирхлын зөрчилтэй зүйлүүд үүсчих эрсдэл байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ дээр бид нар ер нь бодлогын томоохон арга хэмжээнүүдийг авч ажиллахаар төлөвлөж байна. Эрдэнэбат гишүүн болсон тийм ээ? Эрдэнэт гишүүний микрофоныг өгье тодруулга.

С.Эрдэнэбат: Жавхлан сайд нөгөө бид 2 энийг олон л ярьж байгаа. Ер нь бол ахмад, хүүхдүүдэд олгох нийгмийн даатгалыг төр хариуцаж байгаа юм бол яг тэр өртөгт нь нийцүүлж нэмж байж явахгүй бол төр өгөөд байгаа гэдэг талаас нь хараад байвал хамгийн их үйлчилгээ авдаг, хамгийн их зардал гаргадаг хүн хүмүүс чинь хүүхдүүд, ахмадууд байдаг эрүүл мэндийн салбаруудын үйлчилгээ. Тийм учраас би энэ талаас нь бол хараад байгаа юм.

Нөгөө талаараа энэ ЭМД-ын сангийн бие даасан байдлыг нь тавихгүй бол төр мөнгө өгч байгаа учраас бид нар хүү тооцох албагүй гэдэг байдлаар явах юм бол их буруу. Олон улсынхаа жишигээс их хазайгаад явчих учраас би энийг дахин, дахин яриад байгаа. Бодит байдал дээр ЭМД-ын сан илүүдэлтэй, хангалттай байсан бол энийг бол ярихгүй. Тийм учраас энэ тал дээрээ яг эмнэлгүүд дээр манай эмнэлгийн дарга нар хэлэх болов уу гэж бодож байна. 200-гаад тэрбумын авлагатай, энийгээ бид нар авч чадахгүй байна л гэж яриад байгаа юм. Энийг л би асуугаад байгаа байхгүй юу. Тэгэхээр ядаж тэр зардал дээр нь хүү тооцох, өөр хаанаас.../минут дуусав/

М.Ганхүлэг: Асуултад Сангийн сайд Жавхлан хариулна микрофоныг өгье.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж хариулъя. ЭМД-ын сан маань өөрөө жилдээ зарцуулагдаж дуусаад тэг

үлдэгдэлтэй гардаг ийм сан шүү дээ. Тэрнээс биш бусад хуримтлалын сан шиг жил бүр ингээд нэмэгдээд явж байдаг ийм сан ерөөсөө биш. Тийм учраас жил давсан хүү тооцох эд нар гэсэн тийм ойлголт энд бас байж болохгүй. Энэ чинь бусад сангаасаа л өөр шүү. Тийм учраас тэр хүү тооцох гэдгийг бол мартаж хэрэгтэй.

Бас өөр юу гэсэн билээ? Тэр ЭМД-ын сангийн алдагдал, авлага 2 жоохон өөр ойлголт. Авлага гэдэг нь та нөгөө байгууллага эмнэлгүүдийн авлагыг яриад байх шиг байна. Тэр чинь бол хэд хэдэн шалтгаантай байгаа. Яг Сангийн яамнаас ЭМД-ын сангийн орлого бүрдүүлэлт болон зарцуулалт ялангуяа тэр эмнэлгүүд дээрх зарцуулалт дээр нь яг хяналт шалгалт орчихсон хийгдэж байна. Түүн дээр нэлээн асуудал байгаа шүү. Тэр алдагдал гэж яриад байгаа ер нь бас нэлээн хэмжээгээр бас буурах ийм шалгалтын дүн ч гарч байж магадгүй. Тийм учраас.../минут дуусав/

М.Ганхүлэг: Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Өдрийн мэнд хүргэе. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас ядуурлыг бууруулах чиглэлд, Хүүхдийн сангийн талаар асуулт асууна. Эрүүл мэндийн сайдаас цахимжуулалтын талаар асуулт асууна. 2 сайд хоёулаа 3 минутад багтааж хариулахыг хүсье.

1 дүгээрт ядуурлыг бууруулах чиглэлд хамгийн дорвитой үр дүнтэй ажил бол мэдээж халамжаас хөдөлмөрт шилжих бодлогоо гэдэгтэй Энх-Амгалан сайд маань санал нийлэх байх. Энэ хүрээндээ graduation approach буюу төгсөлтийн аргачлалаар бид нийслэлийн 3 дүүрэгт төсөл хэрэгжүүлсэн. Энэ хүрээндээ өргөжүүлж болж байна уу? Ирэх оны хувьд 25 оны төсөв дээр яг энэ халамжаас хөдөлмөрт шилжих ажлын хүрээнд төгсөлтийн аргачлалыг хэрхэн яаж хэрэгжүүлэх талаар та бодлогоо хэрхэн яаж тусгасан вэ гэдгийг нэг талдаа танилцуулна уу?

2 дахь нь болохоор хүүхдийн сангийн талаар. Хүрэлсүх Ерөнхий сайдын үед манай ЗГ яг энэ хүүхдийн санг анх санаачилж батлуулж байсан. Тухайн үед хуримтлагдсан мөнгө одоо арвижаад 19 тэрбум төгрөг болсон байна гэдгийг та өчигдөр ЗГ-ын хуралдааны дараагаар мэдээлсэн. Тэгэхээр тухайн үедээ энэ сан байгуулагдаж байхад Ундармаа жүжигчин маань энэ мөнгийг өөрөө аваад идчихэв үү, энэ Ариунзаяа идчихэв үү, энэ сангийн талаарх санхүүжилт нь хаана яаж зарцуулагдаж байна вэ гэдэг энэ нийгмийн өргөн хэлэлцүүлгүүд явж ирсэн. Тэгэхээр одоог хүртэл энэ сангаас дорвитой яг энэ томоохон бүтээн байгуулалтуудын зардал гарахгүй байгаа нь тухайн жилийн төсөвтөө зарлагаа тусгаж, батлуулах энэ нөхцөл нь ер нь энэ ажлыг хойш нь татаад байсан гэж би бо дотроо боддог. Тэгэхээр өнгөрсөн жилийн хувьд 9,5 тэрбум төгрөг тавигдсан байна. Энэ мөнгө зарцуулагдсан уу? 25 онд 8 тэрбум төгрөг тавигдсан байна. Энэ мөнгө яг төслүүд нь бэлэн байгаа юу? Ер нь энэ сан дээр 19 тэрбум төгрөг төвлөрчихсөн байгааг яг хүүхдэд зориулсан тэр бүтээн байгуулалтад нь уг нь зарцуулмаар байгаа байхгүй юу. Тэгээд журмаа хэрхэн яаж шинэчилсэн юм бэ? Ирэх жил ямар төслүүдэд хөрөнгөө зарцуулах гэж байна вэ гэдэг ийм асуулт.

2 дахь асуулт нь болохоор Эрүүл мэндийн сайдаас энэ цахимжуулалтын талаар. Яг энэ нийгэмд тулгамдаад байгаа эмийг жороор олгох асуудал хувьдаа би ер нь дэмжиж байгаа. Яагаад гэвэл угаасаа жороор олгох ёстой эмийг жоргүй олгож ирсэн энэ практикийг эргүүлээд хуульдаа л нийцүүлж байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ жоргүй олгох эмийнхээ жагсаалтыг 1 дүгээрт нэмэгдүүлэх тал дээр, 2 дугаарт иргэндээ ээлтэй яг энэ цахимжуулалтын цахим жор системийг ИМонгол дээр нээсэн хэдий ч ажиллаж байгаа юу, үгүй юу? Ер нь ЭМЯ-ны энэ цахимжуулалтын ажил яагаад гацаад байна вэ? Цахим эмч, цахим

жор энэ иргэндээ ээлтэй энэ бодлого яагаад хэрэгжихгүй байна вэ гэдгийг асуумаар байна. 2 дугаарт яах вэ нөгөө цахимжуулалтын ажил маань яг яам өөрөө хариуцахгүй ИМонгол академи болон Цахим яам хариуцна гэдэг энэ бодлого маань өөрөө яг ЭМЯ-ны энэ цахимжуулалтын ажлыг хойш нь татаж байна уу эсхүл ямар бэрхшээл байна вэ гэдгийг Эрүүл сайдаас асууя.

М.Ганхүлэг: Тодорхой асуултуудыг асуулаа. Сайд, цаг хугацааны хувьд бол 3 минут аль алинд нь өгөөд явахыг ажлын хэсгийнхэн маань зохион байгуулаарай. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Энх-Амгалан сайдын микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Ариунзаяа сайдын өөрийнхөө эхлүүлсэн ажлуудын гүйцэтгэл юуг л асуугаад байгаа л даа. Зөв л дөө. Халамжаас хөдөлмөрт шилжихэд ямар бодлогын 25 онд ямар бодлогын шинэчлэл хийх гээд байна вэ гэж. Тэгэхээр халамжаас хөдөлмөрт шилжихийн тулд бид нар энэ хөдөлмөрийн зах зээл дээр үүсчихсэн байгаа нөхцөл байдлуудыг их сайн оношилмоор юм байна лээ. Сайн оношилмоор юм байна лээ. Нэг талдаа бид нар ажиллах хүчний хомсдолд орчихсон. 35-аас 40 мянган ажлын байр зарлаад байхад ирж ажилладаг хүн байхгүй болчихсон. Монголчуудын сонголт эсхүл Солонгос явах эсхүл самарт явдаг нэг ийм сонголттой ард түмэн болчих гээд байж байна шүү дээ.

Тэгэхээр бид нар цаашидаа ерөнхийдөө нэг талаасаа би энэ иргэдийг залуучуудыг бас яамааргүй байгаа юм буруутгамааргүй байгаа юм. Мэдээж залуучууд өнөөдөр халамж хавтгайрснаас болоод залуучууд хөдөлмөр хийх сонирхолгүй болсон гэдэг энэ үндэслэл бол 1 дүгээр үндэслэл мөн. 2 дугаар үндэслэл бол ерөөсөө 90-ээс 2019 оны хооронд энэ бага төрөлтийн үеэс болж бид нарын ажиллах хүчний хомсдолд үүсэх хамгийн том шалтгаан болсон юм байна. Үндсэндээ алтан гахай жил хүртэл маш

бага төрөлттэй байсан. Жил бүхэн бид нар хөдөлмөрийн зах зээл дээр ирээдүйд гарах боломжоо жил бүхэн 15-аас 20 мянгаар алдаж байсан. Одоо яг нийт 90-ээс 2019 он гэхээр чинь нийт 19 жилийн турш бид нар бол 200-аас 280 мянган ирээдүйн ажиллах бол хүчнээ алдсан ийм алдагдсан боломж гэж хэлье л дээ. 1 дүгээрт энэнээс болсон хомсдол.

2 дугаарт гадаадад байгаа ажиллаж байгаа 208 мянга байна. Ингээд бараг үндсэндээ хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах ёстой 500 мянган хүнийхээ бид нар боломжийг өнөөдөр алдчихаад байгаа байхгүй юу. 500 мянган хүнийхээ. Тэгэхээр энэ бол хамгийн бүүр язгуур энэ үндэс нь энэ юм байна лээ.

Тэгээд цаашидаа юу гэдэг юм бид нар энэ хөдөлмөрийн зах зээл дээр юу багатай хөдөлмөрийн үнэлэмж багатай байгаа энэ ажлын байран дээр гадаадаас ажиллах хүчин авчрах, ингээд гадаадаас ажиллах хүчин авчрах энэ төлбөрийг чөлөөлөх гээд нэг жаахан уян хатан бодлого баримтлахгүй бол бид нар ингээд хойд хормойгоо аваад, урд хормойгоо нөхөөд ингээд сууж байж ерөөсөө байж болохгүй. Тийм учраас өнөөдөр хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт дээр үүсчихсэн байгаа энэ нөхцөл байдалтай бид нар зөв онош тавьж байж энэ нийлүүлэлтүүдийг бид нар яах юм. Мэдээж мэргэжлийн боловсрол дээр тодорхой асуудлууд байна. Дээд боловсрол дээр бид нар тодорхой асуудал байна. Тийм учраас хөдөлмөрийн зах зээл дээр үүссэн байгаа эрэлт, нийлүүлэлтийг бид нар боловсролынхоо тогтолцоотой уялдуулж байж энэ хомсдолоос гарах ийм зайлишгүй ийм дунд болон урт хугацааны ийм хөгжлийн хэрэгцээ шаардлага үүссэн байгаа.

Ер нь манай иргэд нэг зүйлийг ойлгох ёстой юм байна. Дээд боловсрол төгссөн оюутнуудаас өнөөдөр мэргэжлийн боловсрол төгссөн хүүхдүүдийн өрхийн орлого 40-өөс 60 хувь

илүү байгаа. Авч байгаа цалин 40-өөс 60 хувь байгаа. Тийм учраас дээд боловсрол төгсөөд дипломгүй ажилгүйчүүдийн армид шилжих үү эсхүл мэргэжлийн сургалтаараа дамжаад өндөр цалинтай ажлын байран дээр очих уу гэдэг энэ асуудал бол залуучуудын өмнө маш чухал том сонголтын асуудал байгаа. Тэгээд цаашидаа бид нар ерөөсөө энэ зах зээл дээр бий болсон нөгөө ур чадварын хомсдол гэдэг нэг асуудал үүсэж гарч ирж байна. Тийм учраас энэ ур чадварын хомсдолыг бид нар яаж нөхөх вэ гэдэг дээр түрүүний таны ярьсан тэр нөгөө төгсөлтийн дараах.../минут дуусав/

М.Ганхүлэг: Хүүхдийн сантай холбогдолтой асуултад хариулъя. Энх-Амгалан сайдын микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Хүүхдийн төлөө фондын өнөөдрийн үлдэгдэл дээр 19 тэрбум төгрөг төвлөрсөн байна. Энэний гүйцэтгэл харамсалтай нь 23 он, 24 он дээр энэ гүйцэтгэл гарч чадаагүй. Юунаас болж гүйцэтгэл гарч чадаагүй вэ гэхээр ингээд энэ сангийн захиран зарцуулах журмаас болоод тодорхойгүй байдал үүсчихсэн юм байна лээ. Өчигдрийн ЗГ-ын хуралдаанаар оруулж энэ журамдаа бид нар өөрчлөлт оруулж авсан.

Тийм учраас шинэ орсон өөрчлөлтөөр энэ санд төвлөрсөн хөрөнгийг бид нар хүүхдийн төлөө хийсэн хөрөнгө оруулалт гээд ерөнхий үгээр биш, хүүхдийн төлөө хийсэн хөрөнгө оруулалт тийм ээ, ингээд юу гэдэг юм сургууль, цэцэрлэг эсхүл тусгай хэрэгцээтэй сургууль, цэцэрлэг гэдэг юм уу эсхүл магадгүй Гэмтлийн эмнэлгийн өргөтгөл гэмтэл дээр байгаа хүүхдийн гэмтэл гэнэ, нөгөө эх нялхсын хүүхдийн тоног төхөөрөмж гэх мэтчилнээр улс оронд шаардлагатай байгаа хөрөнгө оруулалтад зарах энэ боломжууд энэ эрх зүйн шинэчлэл бол өчигдрийн журмаар бас бий болсон байгаа шүү. Тийм учраас 25 ондоо бид нар энэ.../минут дуусав/

М.Ганхүлэг: Эрүүл мэндийн сайд сайдын микрофоныг өгье. Цахимжилт болон цаг үеийн асуудалтай холбогдолтой жоргүй болгож байгаа эмийн жагсаалтыг нэмэгдүүлэх чиглэлээр маш тодорхой асуултыг асуусан. 3 минутаар өгөөрэй. Ажлын хэсэг 3 минутаар.

Т.Мөнхсайхан: ИМонголиа бол эерэг тал байна сул, тал байна эрүүл мэндийн салбарын хувьд бол. Жишээ нь жирэмсний хяналтын, дархлаажуулалт зэрэг зүйлүүд дээр ИМонголиа бол үнэхээр өгөөжтэй байна. Энэ цаг захиалах, эмийн жорын асуудал дээр бол тийм зөв оновчтой шийдэл биш байна. Жишээ нь ИМонголиагаар цаг захиалж байгаа улсуудын 40 орчим хувь нь захиалсан цагтаа ирдэггүй, ингээд эргээд хүндрэл үүсдэг асуудал байна. Цахим жорын асуудал бол заавал ИМонголиагаар явах тийм давхардал үүсэх шаардлага байхгүй. Өнөөдөр манай улсад 2500 орчим эмийн сан эм олгож байгаа. Энэнээс 1400 орчим ЭМД-аас хөнгөлөлттэй эм авдаг. Тийм учраас цахим жор маань ийшээ иүүд холбогдох боломж байгаа. Энэ сайдын ажлыг авсан цагаас хойш энэ дээрээ ажиглаж байна.

Ингээд ирэх 7 хоног гэхэд үлдсэн 1100 эмийн санд эргээд эмч нар цахимаар эмээ бичих боломж нь очдог болчихно. Ингээд улсын хэмжээнд 2500 эмийн сан бүгдээрээ эмч нь цахимаар эмийнхээ жорыг бичээд, түүн дээрээ эмийн сан дээрээ цахимаар эргээд эмээ авдаг энэ боломж нь бүрдчихнэ. Тэгэхээр эмийн хувьд цахимжилт ингээд асуудал нь шийдэгдэж байгаа. Цахимжилтын ер нь салбарын хэмжээнд цахимжилт гацаад байгаа гэдэг асуудал байна. Энэний хамгийн гол асуудал бол өнгөрсөн хугацаанд бас энэ маш олон төрлийн программ хангамжууд манай эрүүл мэндийн салбарт байгаа. Энэний хоорондын уялдаа холбоо, мэдээллийг солилцох, асуудлыг нь хангаж байх энэ программ хангамж Дэлхийн банкны төслөөр явсан. Ингээд энэ төслийн явцад маш олон асуудлууд гарч, энэ төсөл

гацаж, хэрэгжихгүйд хүрсэнтэй хамгийн гол холбоотой л асуудал байна.

Одоо гэхдээ энэ хоорондоо мэдээллээ солилцдог асуудлыг шийдэхэд бид нар 4, 5 төрлийн сонголтууд бас байна. Эндээс бид нар хамгийн зөв сонголтоо хийж, ирэх оны нэг сар гэхэд бид нар энэ хоорондоо мэдээллээ солилцдог, иргэд яг өрхийн эмнэлэг дээр очоод бусад эмнэлгүүд дээр хийгдсэн шинжилгээнүүдээ эмч нь харах энэ боломжийг нь бүрдүүлэх тогтолцоо ирэх оны эхнээс бүрдэхэд дөхчихсөн байна.

Нөгөө талаасаа бид нар энэ анхан шатын өрх, сумын эмнэлгүүдийн программ хангамжийн асуудал бас өнөөдрийг хүртэл шийдэгдэхгүй ирлээ. Энэ дээр бид нар тодорхой шийдлүүдийг гаргаад, ирэх оны эхний улирал гэхэд бүх өрх, сумын эмнэлгүүдийн программ хангамжийг нь тодорхой болгоод бусад эмнэлгүүдтэйгээ уялдаа, өрхийн эмнэлгээс бусад эмнэлгүүдийнхээ цагийг оношилгооныхоо цагуудыг авчихдаг энэ тогтолцоог бүрдүүлж байгаа юм. Энэ асуудлууд маань ирэх оны 1 сарын 1 гэхэд бүгдээрээ шийдэгдэхээр ийм тодорхой график энэ ажлууд маань гарчихсан явж байна. Ингээд иргэн өрхийн эмнэлэг дээрээ очоод бүх шинжилгээнүүдээ хардаг, цахимаар бүх эмүүдээ бичүүлээд аль ч эмийн санд очоод авах ёстой эмүүдээ цахим дээрээс нь харж байгаад эмийн сан олгочихдог ийм.../минут дуусав/

М.Ганхүлэг: Ариунзаяа гишүүн тодруулна.

А.Ариунзаяа: Эрүүл мэндийн сайд болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас тодруулга явъя. 1 дүгээрт яг энэ эмийн яг энэ тулгамдаад байгаа асуудал буюу жороор олгох эмийн жагсаалтыг хэрхэн яаж шинэчлэх вэ? Энэ ажил хийгдэж байна уу? Ер нь эмчээс илүү бараг зовлон үзсэн чавганц илүү байдаг гэж хилс яриа хүртэл байдаг шүү дээ. Бид нар өөрсдөө өдөр тутамдаа энэ

эмийг хэрэглээд бүүр зуриил болчихсон. Эмч дээр очихоос илүүтэй зүгээр эмийн санч дээр очоод л ямар эм авах вэ гээд л зүгээр дураараа бичүүлдэг энэ асуудал ер нь буруу гэдгийг эрүүл мэндийн салбар онцолж байгааг бол зүйтэй гэж үзэж байгаа. Гэхдээ эм тодорхой эмүүд үйлдвэрлэгчээсээ хамаараад жороор олгох уу, үгүй юү гэдгээсээ хамаарч энэ чинь нөгөө шударга бус байдал, үл ойлголцлын бий болгоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээрээ шуурхай ямар ажил хийгдэж байна вэ? Хурдан шуурхай засах боломж байна уу? Нэгэн рүүгээ хууль чи баталсан, би баталсан гээд буруугаа чихээд байх биш, яаж энэ асуудлыг хурдан шийдвэрлэх вэ гэдэг дээр нэг асуулт байна.

2 дахь нь болохоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас хүүхдийн сантай холбоотой.../минут дуусав/

М.Ганхүлэг: 1 минут өгье. Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Хүүхдийн сантай холбоотой зарцуулалт нь тухайн төсөвтөө суучихсан байдаг ийм орон зайг журмаараа хуулиараа байгаад байгаа байхгүй юу. Ийм учраас Сангийн яамны зүгээс танд энэ орж ирсэн төсвөөр ирэх жилд 8 тэрбумын л орон зайг өгсөн байна гэсэн үг. Тэгэхээр 19 тэрбумыг бүхэлд нь зарцуулах танд боломж нь байхгүй байна гэсэн үг байхгүй юу даа. Тэгэхээр энэ 19 тэрбумаа бүрэн дүүрэн зарцуулахын тулд та өнөөдөр төсөл чинь бэлэн байх ёстой, 8 тэрбум тусчихсан байгааг 19 болгож нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байна л гэсэн үг. Тэгэхээр энэ 8-даа таарсан төсвүүд төслүүд нь бэлэн байна уу, энийгээ нэмэгдүүлэх боломж байна уу гэдэг ийм асуулт байна.

М.Ганхүлэг: Тодруулсан дарааллаар нь хариулъя. Мөнхсайхан сайдын микрофоныг өгье.

Т.Мөнхсайхан: Манай улсад бүртгэлтэй 4 мянга гаруй төрлийн эм

байна. Тэрнээс 1100 орчим нь жоргүй олгогдох ийм боломжтой. Тэрнээс дотор найрлага бүтэц нь ижилхэн мөртөө зарим нь жортой олгодог, зарим нь жоргүй олгодог энэ давхардал 160 орчим эмд байна. Энэнийхээ бүртгэлийг гаргачихсан. Ингээд Хүний эмийн зөвлөл хуралдаад энэ бүртгэл энэ давхардал энэ ялгааг нь арилгаад, жоргүй олгох ёстой эмийг нь жоргүй олгоё гэдэг энэ шийдвэрээ 1 дүгээрт гаргаад, энэ эмүүдийг эм ханган нийлүүлдэг байгууллагууд руу нь хүсэлтээ өгчихсөн байж байгаа. Ингээд ирэх долоо хоногт дахиад Хүний эмийн зөвлөл хуралдаад эцсийн шийдвэрүүдээ гаргаад, эмийн бүртгэл дээрээ бид нар өөрчлөлтүүдээ хийчихээр ирэх долоо хоног гэхэд ирэх ижил найрлагатай эмүүд зарим нь жортой жоргүй олгодог энэ асуудал бүрэн эцэслэгдэж дуусна гэж ойлгож болно. Энэ асуудал дээр анхаарал хандуулаад өнгөрсөн хугацаанд нэлээн ажлуудыг зохион байгуулж ажиллаж байгаа.

М.Ганхүлэг: Энх-Амгалан сайдын микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Ариунзаяа сайдаа өчигдрийн ЗГ-аар батлуулсан журмаар өмнөх оны үлдэгдэл, ингээд 25 оныхоо төсөв дээр төсвийн төлөвлөсөн төлөвлөлтөөрөө ингээд хүүхдийн сан дээр орж ирэх энэ сангийнхаа төвлөрлийг бид нар захиран зарцуулах хэрэгтэй. Захиран зарцуулахдаа юунд захиран зарцуулах вэ гэдгээ бид нар их ойлгомжтой болгож авсан, их ойлгомжтой болгож авсан. Өмнө нь энэ чинь нэг Тусгай сангийн тухай хуулиар журамлагдаад байгаа юм шиг мөртөө өөрөө бас журамтай ингээд энэ 2 сангийн журам чинь ингээд ойлгогдохгүй учраас өмнөх удирдлагууд чинь ингээд шийдвэр гаргаж чадахгүй байсан юм байна лээ шүү дээ. Яаж ч шийдвэр гаргах вэ угаасаа, энийг буруутгах арга байхгүй.

Тийм учраас өчигдрийн журам нэлээн энэ хөрөнгийн, сангийн хөрөнгө яг

яаж төвлөрөх юм, энэ хөрөнгийг юунд зарцуулах юм, сонгон шалгаруулалтуудыг яг яаж хийх юм бэ гэдэг энэ зүйлүүдээ бид нар их тодорхой болгож авсан. Тийм учраас бол төсөл их байна. Хүүхдийн номын сан барья гэж байна. Хүүхдийн эх нялхсын төв тоног төхөөрөмжийн.../минут дуусав/

М.Ганхүлэг: 1 минутыг нэмж өгье.

Л.Энх-Амгалан: Мэдээж хүүхдийн төлөө хийх асуудал бол Монгол Улсад энэ шиг их юм байхгүй гэж би ойлгож байгаа. Тийм учраас хамгийн гол нь энэ сангийн хөрөнгийг бид нар 1 дүгээрт ил тод, хүртээмжтэй хүрэх ёстой тэр хүүхдүүдэд нь хүрсэн ийм бүтээн байгуулалтын ажлууд, ийм хөрөнгө оруулалтын асуудлууд ийм төсөл, хөтөлбөр байх ёстой л гэж харж байна. Тийм учраас энэ сангийн сонгон шалгаруулалтын төслийн сонгон шалгаруулалтын асуудлыг бид нар удахгүй шинэ журмынхаа дагуу зарлана. Ингээд шинэ төслүүдээ хүлээж аваад, тэгээд бид нар яг ямар хөрөнгө оруулалтад яаж зарцуулах вэ гэдэг ямар шийдвэр гарснаа ард иргэдэд ингээд нээлттэй мэдээлээд явах ийм л шинэ журам ийм зохицуулалттай болсон байгаа.

М.Ганхүлэг: Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууна.

О.Саранчулуун: Сайн байцаана уу. Би нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар нэг асуултыг асуумаар байна. Эрүүл мэндийн энэ зардал дээр Эрүүл Монгол, Элэг бүтэн Монгол, Эрүүл шүд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлнэ гэж байгаа юм. Хөтөлбөр тус бүр дээр 1 тэрбум, 8 тэрбум гээд нэлээн олон мөнгөнүүдийг нэмэхээр ингээд төсөвлөсөн байгаа. Тэгэхээр миний асуулт болохоор энэ мөнгөөр ингээд нэмээд байгаа нь өвчлөлийн тэр өмнөх хэрэгжүүлсэн үр дүнтэйгээ яг ямар

холбоотой юм бэ гэдэг дээр тайлбар авмаар байна. Хөтөлбөр тус бүр дээр.

Хоёрдугаарх нь энэ 3 үндэсний хөтөлбөрийн зардлын бүтэц дотор дандаа эрт илрүүлэг гэгчихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ чинь анхдагч урьдчилан сэргийлэлт, хоёрдогч урьдчилан сэргийлэлт гэж бас байдаг тийм ээ. Тэгэхээр нийт зардлын хэдэн хувь нь анхдагч урьдчилан сэргийлэлт буюу эмнэлгийн тусламж, үйлчилгээ аваагүй оношлогдоогүй хүнийг оношлох тэр түвшиндээ, хэдэн хувь нь хоёрдогч урьдчилан сэргийлэлт буюу бүүр дордохоос нь сэргийлэх чиглэл рүү үйл ажиллагаа төлөвлөж төсөвлөгдсөн юм бэ? Энэ бүтэц дээр нэг тоо өгөөч гэсэн асуулт байна.

Сүүлийн асуулт болохоор энэ дохионы хэлээр duudlaga.mn-ний үйлчилгээ яг 24 цагаар яг болсон уу гэдгийг л яг нэг хариулаад өгөөч. Баярлалаа.

М.Ганхүлэг: Асуултад хариулъя. Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан сайдын микрофоныг өгөөрэй.

Т.Мөнхсайхан: Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөн бол ямар нэгэн байдлаар эрт илрүүлгийг ерөөсөө хийдэггүй. Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөн бол яг өвчний суурь урьдчилан сэргийлэлт буюу аливаа өвчин үүсгэж байгаа шалтгаан нөхцөл, эрсдэлт хүчин зүйлийг арилгах руу чиглэсэн бодлого хийж хэрэгжүүлдэг. Өнгөрсөн хугацаанд бол Монгол хүний эрүүл мэндэд хамгийн их сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа өндөр градустай согтууруулах ундааны хэрэглээг бууруулах чиглэлд хамгийн гол анхаарлаа хандуулж явсан ийм хөдөлгөөн. Үүний үр дүн нь эхнээсээ гараад явж байгаа.

Тэгэхээр ирэх 25 онд дараагийн Монгол хүний эрүүл мэндэд хамгийн их эрсдэл нөлөөлөл үзүүлж байгаа 2 дахь зүйл бол дутуу төрөлт, 3 дугаарт

агаарын бохирдол, 4 дүгээрт тамхидалт, 5 дугаарт артерийн даралтын ихдэлт гэсэн ийм зүйлүүд байгаа. Эд нар луу чиглэсэн энэ эрсдэлт хүчин зүйл шалтгааныг арилгах руу чиглэсэн л бодлого явуулах юм. Тэгэхээр Эрүүл монгол хүн үндэсний хөдөлгөөн дээр бол ямар нэгэн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг байхгүй.

Урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн тогтолцоо маань ЭМД-ынхаа сантай холбогдож уялдаж, санхүүжилт нь тэнчээнээс гарч явж байгаа. Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөр маань сүүлийн нэлээн хэдэн жил хэрэгжиж байгааг та бүхэн маань бүгдээрээ мэдэж байгаа. Энэ дээр гарч байгаа нэмэгдлүүд бол хамгийн гол нь энэ Д вирусээс болж үүсэж байгаа ард иргэдийн эрүүл мэнд, амь насанд үүсэж байгаа эрсдэлийг бууруулах зорилгоор энэ Д вирус хэрэглэх эсрэг хэрэглэдэг эмийн зардлууд нэлээн шингэсэн учраас, орсон учраас энэ дээр ийм зардлын өсөлтүүд гарсан байгаа. Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөний хүрээнд бол ямар нэгэн зардлын өсөлт гараагүй. Энэ шалтгаан руу чиглэсэн бодлого, үйл ажиллагаагаа хийж хэрэгжүүлээд явна.

Тэгэхээр яг үнэхээр нийгмийн эрүүл мэндийн анхдагч суурь урьдчилан сэргийлэлт рүү чиглэсэн ийм хөтөлбөрүүдийг хийж хэрэгжүүлэхэд энэ дараагийн нийгмийн эрүүл мэндийн санхүүжилт маань чиглэж байгаа. Бид нар ер нь жил болгон энэ нийгмийн эрүүл мэнд рүүгээ чиглэсэн өвчин үүсэх шалтгааныг арилгах, эрт илрүүлэг рүү чиглэсэн санхүүжилтээ нэмэгдүүлж байж, ирээдүйд ард иргэд маань өвдсөнийхөө дараа эмчлүүлдэг биш, өвдөхөөс нь урьдчилан сэргийлдэг, өвдсөн тохиолдолд эрт илрүүлдэг энэ бодлого маань биеллээ олж, ард иргэд санхүүгийн эрсдэл дарамтад учрахаас эрүүл мэндээсээ болж санхүүгийн эрсдэл, дарамт, ядууралд өртдөг энэ байдлаас бид нар салах юм. Тийм учраас ирэх, ирэх жилүүдэд нийгмийн эрүүл мэнд рүү

чиглэсэн энэ санхүүжилтээ нэмэгдүүлэх ийм бодлогыг үндсэндээ барьж байгаа гэж ойлгож болно.

М.Ганхүлэг: Дохионы хэлтэй холбогдолтой асуулт асуусан 24 цагаар ажиллах уу гээд. Энх-Амгалан сайдын микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Энийг манай яамны Рэгзэн дарга хариулчих тэгэх үү? Одоо яг нөхцөл байдал юу байгаа юм, тэгээд ирэх онд бид нар яг юу хийхээр төлөвлөж байгаа гэдгийг тодорхой хариулчих.

М.Ганхүлэг: Рэгзэн дарга та 3 номер луу суучих уу? 3 номерын микрофоныг өгье.

С.Рэгзэн: Гишүүний асуултад хариулъя. Одоогоор duudlaga.mn гэдэг энэ манай яамны нийгмийн юу билээ, нэг цэгийн үйлчилгээ дээр 3 дохионы орчуулагч зөвхөн ажлын цагаар буюу 9-өөс 18 цагийн хооронд ажиллаж байгаа. Энэ 3 дохионы орчуулагчийн цалин хөлсний асуудлыг бол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлээд, 24 оны хувьд бол ингээд санхүүжүүлээд явж байгаа. Цаашидаа манай яам дээр И хүртээмж гэдэг аппликэйшнийг боловсруулахаар Хань Про компанитай хамтарч ажиллаж байгаа. Энэ хүртээмж, И хүртээмж гэсэн энэ аппликэйшний тусламжтайгаар цаашидаа бид нар 24 цаг бүх яаралтай тусламж, үйлчилгээнүүдийг үзүүлэх ийм боломжтой болно.

М.Ганхүлэг: Отгоны Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Зардлын бүтэц дээр л би дахиж асуугаад байгаа. Тэгэхээр 1 дүгээр Элэг бүтэн Монгол болон Эрүүл шүдийг бас сайн сонссонгүй. Тэгээд хэрвээ анхны урьдчилан сэргийлэлт анхан шат дээр чиглээд байх юм бол илрүүлээд л, илрүүлээд л байх юм байна. Эрсдэлт хүчин зүйлийг бууруулж байгааг ойлгож

байна. Яг илэрчихсэн, өвдчихсөн, тэгээд эмнэлгийн тусламж авах ёстой өөрөөр хэлбэл хоёрдогч урьдчилан сэргийлэлт буюу өвдсөний дараах нөгөө хүндрэхээс сэргийлэх урьдчилан сэргийлэлт чинь бас л нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт мөн шүү дээ. Тэгэхээр ийшээгээ ер нь энэ зардал ер нь төлөвлөгддөг юм уу? Энэ хүмүүсийн зардлыг ер нь энэ хөтөлбөр дотор огт байхгүй гэсэн үг үү? Миний тэгж ойлгож байгаа зөв үү?

М.Ганхүлэг: Мөнхсайхан сайд хариулах уу? Мөнхсайхан сайдын микрофоныг өгье.

Т.Мөнхсайхан: Эрүүл шүд хөтөлбөр өнгөрсөн хугацаанаас хэрэгжиж эхлээд дандаа шүдийг өвдсөнийх нь дараа эмчлэх бодлого яваад, өнөөдрийн байдлаар шүд нь өвчлөлтэй, амны хөндийн эрүүл ахуй нь энгийн хэвийн байдал нь алдагдсан хүүхдүүдийн тоо буурахгүй байгаа. Тэгэхээр бид нар өнгөрсөн хугацаанд дандаа эмчлэх бодлого хийж, хэрэгжүүлсэн байгаа. Одоо бид нарын цаашдын бодлого юу вэ гэхээр хүүхдүүдээ эмчилье, 6 наснаас нь авхуулаад хүүхдийнхээ шүдийг эмчилье, жилдээ 2 удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулъя.

Дээрээс нь эцэг, эх болон цэцэрлэг, сургуулийн багш нарыг хүүхдүүдийг амны хөндийн эрүүл мэндийн боловсролыг нь олгодог энэ тогтолцоо руу бид нар шилжье гэж байгаа юм. Ер нь урьдчилан сэргийлэх үзлэгийн дийлэнх төсөв мөнгө нь Эрүүл мэндийг дэмжих сангаар явж байгаа, эрүүл мэндийн биш, Эрүүл мэндийн сангаас гарч байгаа. Шаардлагатай Эрүүл мэндийн сангаас даатгалын сангаас гарах боломжгүй төсөв мөнгө зарим нэг тохиолдолд энэ төсөл хөтөлбөрөөс гарах ийм.../минут дуусав/

М.Ганхүлэг: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Энх-Амгалан сайдыг Боловсролын сайд байхад бол манай холбоо маш сайн хамтран ажиллаж байсан. Багш нарын нэлээн олон асуудлуудыг бас шийдэж өгч, боловсролын салбарын багш, ажилтны талархал дэмжлэгийг хүлээж авсан Энх-Амгалан сайдын хувьд. Одоо манай Энх-Амгалан сайд маань бас Нийгмийн хамгааллын яаманд очоод удаагүй байна. Тэгээд Энх-Амгалан сайдаас 4 асуулт асууя.

1 дүгээр асуулт нийгмийн даатгалын сан татаас 1,4 их наяд 24 оноос 277 тэрбумаар нэмэгдсэн. Нийгмийн даатгалын сан ийм их алдагдалтай төсвөөс 1,4 их наядын татаас авдаг болтлоо дамнуурсны шалтгааныг та юу гэж үзэж байна вэ? Энэ дээр нэг тайлбар сонсьё.

2-т нь нийгмийн даатгалын сангаас нэр бүхий банкнуудад мөнгөө тараагаад ингээд олж авч чадахгүй байгаа шүү дээ. Тэгэхээр энийг авч чадахгүй байгаагийн шалтгаан бас юу байна вэ?

3 дугаарт та Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хувьд нийгмийн даатгалын санг алдагдалгүй үр өгөөжтэй болгох тал дээр ямар ажил хийе гэж төлөвлөж байна вэ?

4 дүгээр асуудал Хөдөлмөр нийгмийн зөвшилийн үндэсний 3 талт хороо гээд нэг юу байдаг тийм ээ. Тэрийг та ахалдаг. Энэ хороо бол Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг хэзээ зүй зохистой хэмжээнд аваачих вэ? Миний хувьд бол энэ 3 талт хэлэлцээр бол Монголын ард түмнийг гуйлгачин болгосон хэлэлцээр гэж өөрөө үздэг. Энийгээ ч би илэрхийлдэг. Тэгэхээр энэ дээр бас та ямар өөрчлөлтийг авчрах вэ гэдгийг бас Энх-Амгалан сайдаас асууя.

М.Ганхүлэг: Асуултад Энх-Амгалан сайд хариулна микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Цөмөөрөө яах вэ нийгмийн даатгалын сангийн алдагдал гэж яриад байгаа юм. Энэ бас яг алдагдал гэж бас ойлгож болохгүй юм. Энэ бол ингээд төсвөөс хариуцаж байгаа энэ нийгмийн даатгалын тэтгэврийн сангийн зардлууд нэмэгдээд л жил ирэх тусам нэмэгдээд л яваад байна гэсэн үг. Энэ яг юунаас болоод ингээд нэмэгдээд байгаа юм бэ гэхээр хэд хэдэн ийм улс төрийн уршигтай шийдвэрээс гараад л, өнөөдөр өнгөрсөн хугацаанд гэхэд нийгмийн даатгалын сан дээр 4,7 их наядын бодитой алдагдал л үүсчхэж байгаа байхгүй юу.

Энэ 1 дүгээр асуудал бол Ажилласан жил, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийг бид нар 2012 онд баталсан. Хамрагдсан хүний тоо нь 607 мянган хүн хамрагдсан байна, орлого нь 37 тэрбум төгрөгийн орлого орж ирсэн байна. Нөгөө нэг тэр үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 жилээр үржүүлээд төлчихсөн 60-аас 80 мянган төгрөгийн төлбөр авсан шүү дээ. 37 тэрбум төгрөгийн орлого олсон. Ингээд цаашаа үүгээр нөгөө тэтгэврээ нөхөж төлүүлээд, тэтгэвэрт орсон хүний тоо 324 мянгад хүрээд ингээд үндсэндээ энэ хүмүүст нөгөө 5 жил, 10 жилийн нөхсөнөөс болгоод 37 тэрбум төгрөгийн орлого олсон мөртөө буцаагаад 1,5 их наядын зардал гаргачихсан. 1,5 их наядын зарлага. Энэ зарлага жил бүхэн ингээд нэмэгдээд байна. Жил бүхэн нэмэгдээд байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль 20 онд батлагдаж гарсан. Энэ хуулиар 34 мянган хүн хамрагдаад 76 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн мөртөө буцаагаад 205 тэрбум төгрөгийн зарлага гаргаж байна. Жил бүхэн шүү дээ, жил бүрийн зардлыг. Ингээд шимтгэлийгээ бид нар 2008 онд ингээд энэ НДШ-ийн 19 хувь байсныг 14 хувь болгож буулгасан. Үүнээс болж бид нар 2,7 их наядын алдагдал

үүссэн байна. Ингээд шимтгэлийг бид нар буцаагаад 19 хувь болгочихсон байж байгаад 20 онд 19 хувийг буцаагаад 17 хувь болгож 2 хувиар буулгасан. Үүнээс болж жил бүхэн 308 тэрбум төгрөгийн ачаалал нийгмийн даатгалын сан дээр ирж байна.

Малчдын тэтгэвэрт гарах насыг 5 жилээр наашлуулсан хууль батлуулсан. 32 мянган хүн хамрагдаж, 167 тэрбум төгрөгийн жил бүхэн нийгмийн даатгалын сан дээр ийм ачаалууд ирж байна. Эхний НДШ төлж ажилласан хугацааг хүүхдийн тоогоор нэмэгдүүлсэн 1 аравны, хүүхдийн тоогоор 1,5 жилээр нэмэгдүүлсэн ийм хууль хэрэгжиж эхэлснээс болоод 72 тэрбум төгрөгийн ачаалал шинээр үүссэн байна. Ингээд Зарим иргэний тэтгэврийн хэмжээг 50 мянган төгрөгөөр нэмсэн, 95 оноос өмнөх тэтгэвэрт гарсан хүмүүсийн иргэдийн тэтгэврийн хэмжээг 50 мянган төгрөгөөр нэмсэн. Тэр үеийн Гарамжав гишүүний хуулиас бол 81 тэрбум төгрөгийн ингээд ачаалал ирж байна. Ингээд бүгдийг нь нийлүүлэхээр өнөөдөр ингээд өнгөрсөн хугацаанд улс төрчдийн болон улс төрийн сонгууль дөхсөн ийм шийдвэрээр популист шийдвэрээс гарсан өртөг, улс төрийн өртөг гэж би хэлэх гэж байгаа энийг.

Улс төрийн өртгөөс болж бид нар нийгмийн даатгалын сан дээр 4,7 их наядын ачаалал буюу алдагдал үүсэх ийм шийдвэрийг л бид нар гаргасан байна. Улс төрчид гаргасан байна. Тэгэхээр цаашидаа бид нар Монгол Улс энэ нийгмийн даатгалын энэ сангийнхаа тогтолцооны ер нь тэтгэврийнхээ тогтолцоог бид нар хийхгүй бол ийм хүнээр бол цус алдсан байдлаар ингэж явж бид нар хол явж чадахгүй, хол явж чадахгүй. Тэгэхээр энэ дээр бид нар ер нь тэтгэврийн сангийн тэтгэврийн даатгалын тогтолцооныхоо шинэчлэлийг бид нар хийх ёстой гэж ойлгож байгаа. Энэ Их Хурал ер нь эвслийн ЗГ-ын эвссэн хамгийн гол шалтгааны нэг энэ тэтгэврийн тогтолцооныхоо өөрчлөлтийг хийх ийм

зайлишгүй сонголт, энэнээс өөр бид нар ухрах арга байхгүй болсон гэж ойлгож байгаа.

2 дугаар асуудал энэ Капитал, Чингис хаан банканд эрсдэл үүсчихсэн, би эрсдэл үүсчихсэн байгаа гэж хэлээд байгаа шүү. Яагаад гэвэл өнөөдөр Чингис хаан банк өнөөдөр дампуурлаа зарлаагүй, дампуураагүй банк гэж Монголбанк хэлж байгаа. Тэгэхээр Чингис хаан банкин дээр байгаа.../минут дуусав/

М.Ганхүлэг: Гүйцээж хариулъя, Энх-Амгалан сайдын микрофоныг өгөөрэй.

Л.Энх-Амгалан: Чингис хаан банкин дээр байгаа 100 тэрбум, Капитал банкин дээр үлдэгдэл 60 тэрбум гээд 160 тэрбум төгрөгийн алдагдал юу эрсдэлийг бид нар яаж энэ нийгмийн даатгалын санг эрсдэлгүй болгох вэ гэдэг асуудал дээр бас нэлээн хэд хэдэн арга хэмжээ авч байна. Ингээд би бас энэ Нийгмийн даатгалын үндэсний хорооны дарга болоод анхны хуралдаанаараа яг энэ НДЕГ-ыг прокурорт гомдол гаргах энэ гомдлыг гаргах үүрэг чиглэл өгсөн. НДЕГ прокурорт албан ёсоор анх удаа гомдол гаргасан. Ингээд энэ хэргүүд цаашидаа ингээд шалгагдаад явах ийм нөхцөлүүд үүсэж байгаа. Өнөөдөр бас би Улсын Их Хурлын гишүүдээсээ хүсэж байна. Би өөрийнхөө багцад зарим зардлуудаа хасаад, тэгээд ингээд ирэх жил энэ нийгмийн даатгалын санд үүссэн энэ алдагдал бодитой эрсдэлийг бууруулах чиглэлээр энэ 160 тэрбум төгрөгөө авах чиглэлээр хууль, эрх зүйн зөвлөгөө авъя. 300 орчим сая төгрөгийн зардлуудын, зардлуудыг нэг зардлаас нь хасаад, нөгөө зардлууд дээр нэмэх ийм саналыг манай Үүрийнтуяа гишүүн гаргана гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ дээр манай Байнгын хорооны.../минут дуусав/

М.Ганхүлэг: Тодруулга авах уу? Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүнд микрофоныг өгье тодруулга.

Ц.Мөнхтуяа: Сүүлийн асуулт сайдаа нөгөө Хөдөлмөр нийгмийн зөрчлийн 3 талт хэлэлцээрийн асуудлыг орхисон байна.

М.Ганхүлэг: Энх-Амгалан сайдын микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Энэ 3 талт хэлэлцээрийг бол бүгдэнг нь үгүйсгэж болохгүй байх тийм ээ Эрдэнэбат гишүүнээ. Ингээд энэ бол би хувь гишүүний байр суурь болов уу гэж бодож байна. Тэгэхээр мэдээж энэ 3, энэ аль ч улсад ийм 3 талын хэлэлцээрээр л энэ цалин хөлс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнүүд ингээд л бид нар зохицуулалт хийж явдаг ийм зохицуулалттай шүү дээ. Тэгэхээр энэ би хэлээд байгаа шүү дээ Эрдэнэбат гишүүнээ энэ Мөнхтуяа гишүүнийхээ энэ Монголын багш нарынхаа холбоог та нэг хэлэлцээрт оруулж ир. Та нар битгий ингээд гадуурхаад бай. Ингээд олон улсад бол ийм олон үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл байдаг ийм тогтолцоо байдаг юм байна лээ. Тийм учраас Мөнхтуяа гишүүн Мөнхбаатарынхаа энэ холбоог энэ холбоондоо нэгтгэж, цөмөөрөө ингээд нэг хэлэлцээрт орох тийм нэг талыг болох энэ боломжуудыг нь нээж өгөх ёстой шүү л гэж би хэлэхийг хүсэж байна.

М.Ганхүлэг: Мөнхтуяа гишүүнд дахиад тодруулга 1 минут.

Ц.Мөнхтуяа: Хөдөлмөр нийгмийн зөрчлийн 3 талт хэлэлцээрийг бүхлээр нь үгүйсгэсэн юм байхгүй л дээ. Гэхдээ өнөөдөр Монголын ард түмэн Монголын хөдөлмөрчдийн амьдрал ямар байгаагаас энэ 3 талт хэлэлцээрийн үр дүн угаасаа шууд харагдана. Тийм учраас энийг бол манай багш нар бол энэ 3 талт хэлэлцээрийг бол гуйлгачин болгодог хэлэлцээр гэдгийг бол хүн бүр ярьж байгаа шүү. Би хэлээгүй.

М.Ганхүлэг: Санал хэллээ гэж ойлголоо. Тийм. Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуултаа асууя.

Д.Үүрийнтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Надад ЭМЯ-наас асуух 3 асуулт байна. 1 дүгээрт энэ онд ЭМД-ын сан нэлээд өртэй гарч байгаа. 25 оны төсөв дээр 25 онд гарах зардлаасаа гадна яг энэ өрөө төлж чадах хэмжээний зардлыг бүрэн тусгаж чадсан уу? Магадгүй 25 онд өрөө төлчхөөд, эргээд оны төгсгөлд бас энэ оных шиг нөхцөл байдал үүсэх юм биш биз дээ. Энэ дээр ямар төлөвлөлт хийж байгаа вэ 1 дүгээрт.

2 дугаарт Улаанбаатараас алслагдсан томоохон аймгийн төвүүд ялангуяа олон хүн амтай аймгийн төвүүд дээр байгаа нэгдсэн эмнэлэг дээр компьютер томограф, MRI гэх мэтчилэн яаралтай тусламжийн оношилгоо хийх шаардлагатай аппарат, тоног төхөөрөмж байхгүй хэчнээн аймаг улсын хэмжээнд ер нь байна вэ? Энэ онд хэд нь шийдэгдэхээр төлөвлөгдөж байгаа вэ?

3-д нь иргэний эрүүл мэндийн хариуцлагын асуудлыг ер нь бид хэзээнээс тооцож ярьдаг болох юм бэ? Тухайлбал архи, тамхины хэтрүүлсэн хэрэглээнээсээ болоод зүрх судасны өвчлөл юм уу эсвэл дотоод шүүрлийн асуудлууд үүсээд маш өндөр үнэтэй хагалгаа, үйлчилгээ эмнэлгээс авдаг. Энэ төлбөр улсаас хийгдээд яваад байдаг. Гэтэл иргэний хариуцлагын хувьд энд ер нь ямар хариуцлага хүлээх ёстой юм бэ? Энэ дээр яам ямар бодлого барьж байгаа вэ гэж.

Дараа нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд нэг асуулт байна. Энх-Амгалан сайд та тэтгэврийн санд 4,7 их наядын алдагдал үүсчихлээ гээд сүүлийн үед нэлээдгүй мэдээллүүд яваад байгаа. Тэгээд энэ ямар байдлаар үүссэн алдагдал юм бэ? Ямар бодлого, ямар хөтөлбөрөөс энэ алдагдал үүсэж вэ? 25 онд энэ алдагдлыг ер нь хэрхэн шийдвэрлэхээр төлөвлөж байгаа юм бол?

Үндэсний аудитын газраас нэг асуулт асууя. Орон нутагт хийгдэж

байгаа энэ хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд ер нь хамгийн сүүлд хэзээ аудит хийгдсэн юм бэ? Ялангуяа бидний хэлэлцэж байгаа энэ нийгмийн асуудлууд сургууль, цэцэрлэг, дотуур байр, соёлын төв, спорт заал гээд. Зарим гүйцэтгэгчид нь ажлаа хаяад алга болчихсон 10 жил үргэлжилж байгаа ажлууд хүртэл байна. Улсын хэмжээнд яг энэ гүйцэтгэл нь хаягдчихсан, гүйцэтгэгч компани нь шүүхийн асуудал дээр оччихсон, цаашид үргэлжлэх боломжгүй болчихсон хэчнээн их хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд байна вэ? Энэ талаар хийгдсэн мэдээлэл байна уу гэж. Баярлалаа.

М.Ганхүлэг: ЭМЯ асуултад хариулъя. Мөнхсайхан сайдын микрофоныг өгье, 3 минутаар аль алийг нь 3 минутаар.

Т.Мөнхсайхан: Энэ оны эхний байдлаар даатгалын сангийн авлага 218 тэрбум байсан. Ингээд энэ оны төгсгөл санхүүжилтийн хугацаа дуусахад ер нь нэмээд 200 орчим тэрбум төгрөгийн бас өртэй гарах ийм эрсдэл байна. Ирэх оны төсөв дээр 305 орчим тэрбум төгрөгийн нэмэгдлийг тусгасан. Тэгэхээр энэ авах авлага, өр зээлийн асуудал дийлэнх хувь нь 80, 90 орчим хувь нь ингээд ирэх оны төсөв дээр шийдэгдээд суусан гэж ойлгож болно.

Энэ хөдөө орон нутгуудад ер нь бүх аймгуудад компьютер томограф бол ингээд суурилагаад дууссан байгаа. Харин MRI тоног төхөөрөмж зарим нэг Бүсийн оношилгоо, эмчилгээ төв дээр байх нь зайлигүй шаардлагатай. Заавал Улаанбаатар орохгүйгээр тухайн бүсдээ оношилгоогоо хийлгээд, эмчилгээгээ хийлгэх энэ боломжийг бүрдүүлэх ёстой гэдэг энэ тогтолцооны хувьд бодлогын хувьд ингэж явж байгаа. Тийм учраас ирэх жил ялангуяа хөдөө орон нутгийн эмнэлгүүдэд энэ шаардлагадаа оношилгооны тоног төхөөрөмж болон эмчилгээ, мэс заслын тоног төхөөрөмжийг шийдэх зорилгоор 45

тэрбум төгрөгийг тусгасан байгаа. Үүгээр бид нар аймгуудад тулгамдсан байгаа асуудлаа шийдэж, Улаанбаатарт энэ төвлөрсөн тусламж, үйлчилгээ бий 21 аймагтаа аль болох оношилгоогоо эмчилгээгээ хийлгэх боломжийг нь бүрдүүлэх энэ бодлого маань ирэх жилээс бас биеллээ олох боломжтой ийм төсөв мөнгөнүүд тодорхой хэмжээгээр суугдсан байгаа.

Иргэний эрүүл мэндийн хариуцлагын асуудал бид нар ярихгүй бол болохгүй байгаа. ЭМД-ын сангаас дааж байгаа хувь нь 98, хувь хүний халааснаас гарч байгаа санхүүжилт нь ерөөсөө 2-хон хувь байгаа. Энэ бол олон улсын аль ч улсад байдаггүй ийм тогтолцоо. Бид нар ер нь иргэдээ өвдөөд бай, бүгдийг нь бид нар эмчлээд байя гэдэг бодлого өнгөрсөн хугацаанд явжээ гэдгийг харуулж байгаа юм. Тийм учраас бид нар ЭМД-ын сангаас даах ёстойгоо даах ёстой, харин иргэн өөрөө сэргийлж болох өвчлөлөөр өвдсөн тохиолдолд илүү их хамтын төлбөрийг нь иргэнээс нь гаргадаг энэ тогтолцоог бий болгоё. Тийм учраас бид нар ер нь энэ ЭМД-ынхаа тухай хуульд томоохон өөрчлөлт оруулж, энэ төр даах иргэдийнхээ энэ хувь хэмжээг нь бас тодорхой болгох, энэ шимтгэлээ өөрсдөө төлдөг иргэдийнхээ төлдөг хувь хэмжээг тодорхой болгож, ер нь даатгалын сангийн орлого талаа тодорхой болгох, нөгөө талдаа бид нар зарлага талдаа хувь хүний хариуцлагыг нэмэгдүүлж, хамтын төлбөрийг нь зөв болгох, даатгалын сангийн санхүүжилтийг оновчтой өгөөжтэй болгох асуудал.

Мөн энэ эрүүл мэндийн байгууллагуудын зарцуулалтыг маш оновчтой зөв зохион байгуулалтад бид нар оруулж чадах юм бол бид нар эргээд энэ иргэдийнхээ энэ эрүүл мэндэд томоохон ядуурал, санхүүгийн эрсдэлд учруулахгүйгээр даатгалын сангаасаа санхүүжилтүүдээ хийгээд явах боломжууд бас байна л гэж харж байгаа.

М.Ганхүлэг: Тэтгэврийн сангийн алдагдалтай холбогдолтой асуудлаар Энх-Амгалан сайд хариулах уу, 3 минутаар өгчхөөрэй. Энэ бас нэлээн дэлгэрэнгүй тодруулах асуудал байгаа.

Л.Энх-Амгалан: Үүрийнтуяа гишүүн маань маш чухал асуудал хөндөж асууж байгаа. Бид нар ер нь энэ тэтгэврийн даатгалын сан дээр ирж байгаа энэ алдагдал өнгөрсөн хугацааны улс төрийн шийдвэрүүдээс болж богино хугацааны шийдвэрүүдээс болж гарсан үр дүнгүүдээс бид нар ийм их том хэмжээний алдагдал бодитойгоор хүлээчхээд байна. Энэ 4,7 их наяд гэж байгаа. Тэгэхээр 4,7 их наядын задаргааг би бас би түрүүн Мөнхтуяа гишүүний асуултад хариулахдаа хариулчихсан учраас энийг би бас дахиж нуршаад яах вэ гэж бодож байна.

Энэ жилийн магадгүй гишүүдэд энэ нь сонин байж магадгүй. Энэ жил дөрөв аравны, 1,4 их наядын алдагдлыг төсвөөс татвар төлөгчдийн мөнгөөр санхүүжүүлэх ийм бодитой нөхцөл байдал үүссэн. Энэ жил 1,4 их наяд, ирэх жил 25 онд, 26 онд бид нар 2,6 их наяд, 27 онд 2,9 их наяд, хоёр аравны юу, 28 онд 4 их наядын энэ алдагдлыг төсвөөс санхүүжүүлэх ийм бодитой эрсдэл бид нарт нүүрлэхээд байгаа юм. Тэгэхээр ганцхан асуудал бид нар үндсэндээ энэ тэтгэврийн тогтолцооны шинэчлэлээ цаг алдалгүйгээр хийхгүй бол өөр сонголт байхгүй гэдгийг бүүр дахин хэлье гэж бодож байна.

Нэгэнт Үүрийнтуяа гишүүн маань асуусан учраас энэ жилийн энэ жилийн 1,4 их наядын энэ төсвөөс санхүүжүүлж байгаа санхүүжилт яг юу юуг санхүүжүүлж байгаа юм бэ гэдэг манай гишүүдэд, ард иргэдэд их ойлгомжтой юу сонирхолтой байж магадгүй гэж бодож байгаа. 1 дүгээрт нь энэ иргэдийг төрөөс иргэд тэтгэврийг нь хариуцах иргэдийн улсын төсвийн санхүүжилт гээд, төрөөс тэтгэврийг нь хариуцдаг 60 мянган хүн байна, 60 мянган хүн. Энэ 60 мянган хүний

тэтгэврийн төрөөс хариуцаж байгаа тэтгэврийн хэмжээ өнөөдөр 758 тэрбум болсон байна, 758 тэрбум. Тэтгэврийн даатгалын сангийн 95 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэрт 36 мянган иргэдийн иргэдэд бид нар 308 тэрбум төгрөг төгрөгийн санхүүжилт хийх гэж байна.

Мэргэжил үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 95 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэрт нийт 421 хүнд 5 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгох, Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуулийн дагуу болох тэтгэврийн нэмэгдэлд 27460 хүнд 16,4 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан өндөр настны тэтгэврийн тусгай зохицуулалтын дагуу болох тэтгэврийн нэмэгдэлд хамрагдах иргэдийн тоо 14 мянга, энэ 14 мянгад бид нар 18 тэрбум төгрөг. Цэргийн тэтгэвэр авдаг 23 мянган хүн байдаг. Нөгөө энд эрт насандаа тэтгэвэрт гардаг, 40 нас хүрэхгүй тэтгэвэрт гарчихсан манай залуучууд байгаа шүү дээ. Энэ залуучууд 23 мянган энэ залуучуудад бид нар жил бүхэн 410 тэрбум төгрөгийн тэтгэврийг төсвөөс татвар төлөгчдийн мөнгөөр олгож олгож байгаа. 37 насандаа тэтгэвэрт гарч байгаа шүү дээ тийм ээ. Ингээд энэ бүхнийг нэмэх юм нийт 1,4 их наядын зардлуудыг төсвөөс санхүүжүүлэх.../минут дуусав/

М.Ганхүлэг: Үндэсний аудитын газраас асуулт асуусан. Орон нутагт хэрэгжиж байгаа энэ төслүүд дээр, чухал асуултад тодорхой хариулаарай. Үндэсний аудитын газар 3 номер, өөрийгөө танилцуулаад та хариулаарай.

Д.Энхболд: Үндэсний Аудитын газар Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал Энхболд. Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газраас жил бүр улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө

оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд бол аудит хийж, 6 сард бол төсвийн гүйцэтгэлийн аудиттай нэгтгэн Их Хуралд танилцуулдаг байгаа. Тэгэхээр жил болгон энэ аудитын үйл ажиллагаа бол явагдаж байгаа.

Орхон аймаг дахь аймагт хэрэгжсэн улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний тайланг бол тусад нь танд хүргүүлье. Өнгөрсөн жил бол энэ дээр Орхон аймагт тусгайлан Үндэсний аудитын газраас бол ажлын хэсэг гаргаж ажиллуулсан байгаа. Тухайн төсөл, арга хэмжээнүүдийн тайланг бол танд нэгдсэн байдлаар хүргүүлье.

М.Ганхүлэг: Үүрийнтуяа гишүүн тодруулна.

Д.Үүрийнтуяа: Эрүүл мэндийн сайдаа энэ онд тусгагдсан 45 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хэд хэдэн аймаг MRI-тай болох боломжтой байгаа вэ? Энэ дээр нэг тодотгоод хариулаад өгөөч. Үндэсний аудитын газар би Орхон аймгийн асуудлыг онцгойлон сонирхсонгүй л дээ. Улсын хэмжээний дүн мэдээ авъя гэсэн юм. Би зүгээр ганц л жишээ хэлье. Яагаад энэ асуудлыг бас хөндөж яриад байна вэ гэхээр орон нутагт ажиллаж байхад бас олон сумууд дээр ийм асуудлууд үүссэн байна. Тухайлбал Хөвсгөл аймаг Арбулаг сум дээр сургууль, сургуулийн барилга, спорт заалтайгаа хамт хийгдэхээр төлөвлөгдсөн техникийн даалгавар нь. Гэтэл өнөөдөр спорт заал нь баригдаагүй байхад Улсын комисс хүлээгээд авчихсан. Сургуулийн барилга баригдаагүй 10 жил болж байгаа сум байна. Тэгээд энэ төсвийн хөрөнгө оруулалт дээр ямар арга хэмжээ авч байгаа юм бэ? Шалгалтын мөрөөр.

М.Ганхүлэг: Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан сайдын микрофоныг өгье.

Т.Мөнхсайхан: Бид нар ер нь эхлээд өгөөжүүдээ нэлээн их судалж байгаа юм. Бид нар ер нь тэр үнэтэй

тоног төхөөрөмжүүдийг авахдаа үнэхээр ашиглалт нь өндөр хэмжээнд байж чадах уу? 1 MRI аппарат чинь 5,2 тэрбум орчим төгрөгийн өртөгтэй байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар энэ тооцооллуудаа хийгээд ер нь эхний ээлжид яг замын сүлжээ төв цэг дээр байрладаг ийм 4 аймгуудад ер нь байх нь зөв юм уу гэдэг тооцооллоо гаргаад энэ дээр ажиллаж байгаа. Энэ дээр бол Эрдэнэт бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Өвөрхангай, Хэнтий, Дундговь гэх мэтчилэн энэ аймгууд дээр бид нар ер нь судалгаануудаа хийгдээд, гол нь Улаанбаатар луу наашаа ирдэг биш, Улаанбаатар луу ирэхгүйгээр тухайн бүсдээ төв замынхаа дагуу энэ оношилгоог авах боломжтой энэ талаас нь судалж тооцоолж бид нар гаргаж байгаа. Баярлалаа.

М.Ганхүлэг: Тэр чухал асуулт асуугаад байна л даа. Мааш тодорхой, ер нь яг хийгдэж байгаа ажлуудтай холбогдолтой олон төслүүд бас гацдаг. Гацсантай холбогдолтой дахиад төсвүүд бас нэмэгддэг. Тэгээд энэ дээр тодорхой бас дахин хариулт өгье. Үндэсний аудитын газар 3 номер.

Д.Энхболд: Үндэсний аудитын газар Энхболд. Хөрөнгө оруулалтын аудитаар хэд хэдэн анхаарах асуудлууд гарч байгаа. Энэ дээр бол бид нар акт, албан шаардлага, хууль, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн хянуулах ийм шийдвэрүүдийг гаргаж байгаа. Гол анхаарах асуудал бол 1 дүгээрт таны ярьж байгаатай санал нэг байгаа. Иж бүрэн төлөвлөлт байхгүй, анхнаас нь төсөл, арга хэмжээг батлахдаа хэсэгчилсэн байдлаар баталдаг, төлөвлөлтийг иж бүрэн төлөвлөдөг асуудал бол хангалтгүй байдаг. Нөгөө талаас бол орон нутагт хамгийн их анхаарах асуудал бол захиалагчийн хяналт хангалтгүй хийгдэж байгаа. Энэ дээр орон нутагт захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа байгууллагууд дээр мэргэжлийн хүмүүс ажиллахгүй байгаа ийм тохиолдлууд маш их байгаа. Энэ дээр бол

бид нар тусгайлан судалгаа хийж үзсэн. Захиалагчийн хяналт хэрэгжүүлж байгаа байгууллагууд дээр бол мэргэжлийн.../минут дуусав/

М.Ганхүлэг: Нэмэлт, гүйцээж хариулъя, нэмээд 1 минут өгчихье.

Д.Энхболд: Мэргэжлийн инженер, техникийн ажилтнууд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх түвшний хүмүүс байхгүй байна гэдэг ийм дүгнэлтийг хийгээд, Улсын Их Хурлын болон холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт нь энэ тал дээр анхаарч ажиллах чиглэлээр бол зөвлөмж өгч ажилласан байгаа.

М.Ганхүлэг: Дахиад нэг боломж байна. Үүрийнтуяа гишүүн дахиад тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Энэ орон нутагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын асуудлууд бол үнэхээр тулгамдсан асуудал болоод байна. Энэ дээр үнэхээр бид нар нэг юу гэдэг юм хууль хяналтын байгууллагад шилжүүлээд ямар нэгэн үр дүн гарч байгаа юм алга. Миний миний саяын хэлдэг 2 жишээ дээр гүйцэтгэгч 2 компанийн алиных нь ч тендерт орох эрх нь хязгаарлагдаагүй, хар жагсаалтад ороогүй явж байгаа нөгөө гүйцэтгэгч 2 компани өнөөдрийг хүртэл. Гэтэл бид нар энэ төсвийн хөрөнгө оруулалтыг үр өгөөжгүй болгож байгаа, үр дүнгүй болгож байгаа энэ хариуцлагагүй газруудтайгаа хариуцлага тооцохгүй байх юм бол дараа дараагийн асуудлууд маань хоорондоо цаас шидээд л үргэлжлээд л байх нь л дээ.

Энэ оны хувьд бид нар бас багагүй хөрөнгө оруулалтын асуудлуудыг тавьж байгаа. Тийм учраас цаашидаа энэ өмнө нь хийгдсэн үр дүн нь гараагүй улсын хэмжээнд байгаа энэ бүх объектуудын судалгааг гаргаж, энэ дээр дорвитой арга хэмжээ авч, хууль хяналтын байгууллагатай хамтарч ажилламаар байна. Шаардлагатай бол хууль, эрх зүйн

орчиндоо өөрчлөлт оруулмаар байна. Тухайлбал энэ улсын комисс хүлээж авч байгаа.../минут дуусав/

М.Ганхүлэг: Ерөнхий санал гэж ойлгоод, Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүний микрофоныг өгье. Дараагийн асуулт.

М.Нарантуяа-Нара: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Эрүүл мэндийн яам, Соёлын яам, мөн түүнчлэн эхлээд Боловсролын яамнаас асуулт асууя. Ийм 3 яамнаас. Тэгэхээр Боловсролын яамнаас асуухад хүүхдэд боловсролыг тэгш хүртээмжтэй хүргэх, тэгээд бага насны хүүхэдтэй эцэг, эхчүүдийг хөдөлмөр эрхлэх боломжийг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхтэй холбоотой ийм төсөвт нарийн суугдаагүй байна л даа. Тухайлбал 2025 онд энэ 90 сургууль, 62 цэцэрлэг ингээд барих цэцэрлэгийн барилга барих ийм төсөв орж ирж байгаа. Гэтэл энэ сургууль, цэцэрлэгийн барилгууд чинь үнэхээрийн хүн амын төвлөрөл ихтэй байгаа бүсэд, тухайлбал, саяхан 3 ээлжээр ажиллаад шөнө дөл цагаар хүүхдүүд тарж байгаа, хүүхдүүдийн аюулгүй байдал эрсдэл үүсэж байгаа энэ бүсүүдэд баригдаж байгаа юу?

Тэгээд дээрээс нь бас сургуулийн хөтөлбөртэй холбоотой. Жишээлбэл 151 дүгээр сургуулийг сая Кембрижийн хөтөлбөртэй сургууль болгоод, 5 жилийн хугацаанд Кембрижийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гээд ингээд гараад ирсэн. Энэ Кембрижийн хөтөлбөр миний мэдэхээр бол жил болгон яг энэ төсөв шиг ингэж бид нар хөтөлбөрийг ингэж хэрэгжүүлсэн, энэ хэрэгжүүлсний үр дүнд дараа жилийнхээ хөтөлбөрийг ингээд дахин батлуулаад авдаг ийм хөтөлбөр байдаг. Гэтэл яаж энэ 5 жилийн хөтөлбөрийн амлалтыг хаанаас гаргаад ирэв? Дээрээс нь энэ Кембрижийн хөтөлбөрийн санхүүжилтийг яаж шийдэх гээд байгаа юм бэ?

Энэ Кембрижийн хөтөлбөртэй сургуулийн асуудлыг хөндсөн дээрээ улсын төсөвтэй Кембрижийн 4 сургууль байж байна. Энэ Кембрижийн хөтөлбөрийн сургуулийн, хөтөлбөртэй сургуулиудын гол чиглэл, ач холбогдол, зорилго нь юундаа оршоод байгаа юм бэ? Жишээлбэл жил бүр Кембрижийн хөтөлбөртэй улсын сургуульд оруулахын тулд 800 орчим хүүхдүүд дагасан дамжаанд явж байгаад, дамжаа хөтөлбөрт сурч байгаад, энэ дамжаанаасаа ердөө жилд 40-хөн хүүхэд шалгаруулж авдаг. Өөрөөр хэлбэл энд хүүхдүүдийг боловсролын түвшинээр нь бас ингээд ялгаварлан гадуурхаж байгаа нөхцөл харагдаж байна. Дээрээс нь энэ 13 жил хэрэгжсэн энэ Кембрижийн хөтөлбөр чинь өнөөдөр яг ямар зорилгод хүрээд энэ ингээд хэрэгжээд яваад байгаа юм бэ? Төрийн бодлого гэдэг бол нийтээр нь дээшлүүлэх бодлого байдаг болохоос биш нэг хэсгийг нь тордох ийм бодлого байж болохгүй гэж би хувьдаа бодоод байгаа.

Гэтэл энэ Кембрижийн хөтөлбөр чинь ямар ч зорилго, үр өгөөж, ашиг шимээ тодорхойлохгүйгээр, хэмжихгүйгээр ингээд үргэлжлээд яваад байгаа нь юутай холбоотой вэ? Мөн дээрээс нь, 18 секунд дутуу байна уу. Тэгээд ийм байгаа. Тэгээд энэ сургуулийн гуанзны асуудал. Багш нар чинь өмнөх үндсэн асуудлаа ажлаа дийлэхгүй байж байхад сургуулийнхаа гуанзанд ороод ингээд бэлтгэгч, угаагч хийгээд явж байгаа энэ асуудлыг энэ Боловсролын яам яаж шийдэх гээд байна вэ? Энэ.../минут дуусав/

М.Ганхүлэг: Гишүүддээ бас сануулаад хэлье. Энэ Байнгын хорооны эрхлэх асуудал гэж байгаа. Эрхлэх асуудалтай холбогдолтой үндсэндээ Боловсролын яамтай холбогдолтой бол мэргэжлийн боловсролын сургалтын төвтэй холбогдолтой асуудал нь манай Нарантуяа-Нара гишүүнээ манай Байнгын хороонд хамаарч байгаа юм. Тэгэхээр хэдүүлээ бол яг энэ мэргэжлийн боловсролын асуудлаар бол асуулт асуух

боломжтой. Бусад асуудлыг нь бол БСШУ-ы байнгын байнгын хороонд та орж бас асууж болно. Боловсролын яамныхан саяын бас чухал асуудлууд асууж байна. Үүнтэй холбогдолтой бичгээр бас саналуудыг та бүхэн өгөх нь зөв байх гэж бодож байна.

Тэгэхээр Боловсролын яамнаас бол мэргэжлийн боловсролын асуудал, Соёл, аялал жуулчлал, спорт, залуучуудын яамнаас бол залуучуудын асуудал нь бол манай Байнгын хороотой хамааралтай асуудал байгаа юм. Тэгэхээр та бүхэн маань энэ 2 чиглэлээр нь аль болох асуултаа асуугаарай. Нөгөө 2 яамны асуудлууд бол бүгд манайхтай хамааралтай байгаа гэдгийг хэлье. Тэгэхээр тодруулахдаа та энийгээ анхаараад, дахиад тодруулъя. Нарантуяа-Нара гишүүнд тодруулгын минут өгье.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр уг нь би асуултаа үргэлжлүүлээд явах уу, ЭМЯ-наас асуумаар байсан. Энэ бол ер нь тодруулга шинжийн. Жишээлбэл ЭМЯ 40 тэрбумаар эмнэлгийн байр худалдаж авах гээд тэгчихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ нь яг ямар эмнэлгийн, яг ямар зориулалтын байр вэ гэдгийг бас би тодруулмаар байсан. Соёлын яам дээр жишээлбэл 24 тэрбумаар 25 онд тоног төхөөрөмж авах ийм улс даяар тоног төхөөрөмж авах ийм төсөв орж ирсэн байгаа. Эдгээрийн дэлгэрэнгүй задаргааг би яамнуудаас нь хүсмээр байна.

М.Ганхүлэг: Саяын Боловсролын яамтай холбогдолтой асуудлыг төлөөлж байгаа гишүүд маань тэмдэглэж аваад, бичгээр болон бас холбогдох Байнгын хороогоор нь дамжуулаад мэдээллийг нь өгүүлээрэй. ЭМЯ-наас асуусан асуултад Мөнхсайхан сайд хариулах уу.

Т.Мөнхсайхан: Эмнэлэг худалдаж авах асуудал өнгөрсөн 23 оны төсөвт суусан юм байна лээ. БЗД-т одоо үйл ажиллагаа явуулдаг эмнэлэг маань ер нь менежментийн хувьчлалаар явсан улсад

хамаардаггүй. Тэгэхээр БЗД маань өөрсдөө эмнэлэгтэй болох зорилгоор энэ худалдан авалт хийхээр хөрөнгө тавиулсан юм байна лээ. Тэрнийхээ 5 тэрбумыг нь энэ оны төсөвт тавиулсан. Ингээд ирэх оны төсвүүдэд үлдэгдэл төлбөрийг нь хийнэ гэдэг байдлаар төсөв мөнгө тавигдсан юм байна лээ. Гэхдээ түүн дээр яг энэ жилийн байдлаар тэр барилга худалдан авалт хийх явц нь тендер нь зарлагдаад шаардлага хангах зүйлүүд ороогүй учраас энэ барилга худалдан авах ажил маань одоогийн байдлаар тендерийнхээ шатанд явж байгаа гэсэн үг. Баярлалаа.

М.Ганхүлэг: Соёлын яамных мөн адилхан. Соёлын яам бол залуучуудын асуудалтай холбогдолтой асуудал манайтай хамааралтай. 2 гишүүний дараа санал хураалт явагдана. Байнгын хорооны гишүүдийг танхимдаа орж ирэхийг сануулаарай манай ажлын хэсгийнхэн. Дараагийн асуулт асуух гишүүн Ганмаа гишүүн. Улсын Их Хурлын гишүүн Ганмаа гишүүний микрофоныг өгье.

Д.Ганмаа: Сайн байцаана уу, та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би 3 асуулт, 1 нь ЭМД-ын сангийн авлага, алдагдлын асуудлаар, дээрээс нь энэ дээр сайдын багцын урсгал талаар, 3 дугаарт энэ Төсвийн хуулийн хэлэлцүүлэг дээр хавсралт 1 дээр байгаа хэдэн шалгуур үзүүлэлтийн талаар мэргэжлийн яам байгаа учраас асууя гэж бодож байна.

1 дүгээрт сая бас асууж байна. Тэгэхдээ ЭМД-ын сангийн 130 орчим тэрбум төгрөг Капитал, Чингис банканд байршуулаад тэгээд банкны хураагдсан хөрөнгөөс шийдэгдэх гэж байгаа гэсэн асуудал яригдаж байгаа. Энэ ямаршуу түвшиндээ хаана явж байгаа юм бол? Сая бас асуултад сайд 218 тэрбум төгрөгийн өр, тэгээд дээрээс нь нэмээд 200 тэрбум төгрөг. Тэгэхдээ 2025 оны 305 тэрбум төгрөг бол тавигдчихсан байгаа гэж хариулж байна. Тэгэхээр энэ дараа жил жишээлбэл нэхэмжлэлүүд

нэмэгдээд, эмнэлгүүдийн асуудлууд, хангамжийн асуудлууд гараад, дахиад эмч, эмнэлгийн ажилчдын цалин мөнгө хомсдох энэ асуудал гарах уу эсвэл энэ асуудлууд гайгүй ер нь шийдэгдчихнэ гэж үзэж байгаа юу? Тэр нэг асуулт.

3 дахь буюу энэ шалгуур үзүүлэлтийн тал дээр бас гүйцэтгэл дээр бид нар яригдаж л таарах байх. Энэ шалгуур үзүүлэлтээ маш тодорхой мэргэжлийн түвшинд аваачихгүй бол энэ их том асуудлууд дагуулж байна. Зүгээр цөөхөн асуудлыг минутдаа багтаад асууя. Хавсралт 1 дээр жишээлбэл нийгмийн эрүүл мэнд буюу эрт илрүүлэг тал дээрээ л илүү өвчтүүдийг авсан юм болов уу гэж би тааж байна. Тэгэхдээ энэ дээр яг артерийн даралт, чихрийн шижин, умайн хүзүүний эрт илрүүлэг гэж хэлье гээд яг энэ 3 өвчлөлийг авсан үндэслэл нь юу нь юу юм бэ тийм ээ, ямар арга, аргачлалаар явж байгаа юм бэ? Яагаад энэ шалгуур үзүүлэлт буюу KPI дээрээ дөнгөж 0,1, 0,2, 0,9-өөр нэмэгдэхээр тавьж байгаа юм бэ? 61,9-ийг 62 болгоно ч гэдэг юм уу, 79,1-ийг 80 болгоно ч гэдэг юм уу.

Энэ нь тэгээд 2025 онд хүрэх ёстой тэр нөгөө Алсын хараа дээр байгаа тоотойгоо зөрөөд багассан байдлаар орж ирж байна. Энэний уялдаа холбоог бас тайлбарлаж, ярьж өгвөл их сайн байна. Тэгээд эмнэлгийн тусламж, үйлчилгээ дээр асуулт нь бас хэд хэдэн хэдэн юмнууд байгаа. Мөн харьцангуй тоон хувиар орж ирж байгаа. Нөгөө нэгжүүд нь зарим нь промилле зарим нь продецимилле гэж явмаар юм шиг байгаа юм. Яагаад гэхээр 100 мянгад ч адилхан промилле гээд л, 10 мянгад байгаа тохиолдлоо ч гэсэн промил гээд явчихсан байна. Энэ бол яах вэ үг үсгийн алдаа, энийгээ засах боломжтой байх гэж харж байгаа.

Дараа нь эмнэлгийн хэвтэж эмчлүүлж байгаа хүмүүсийн ханамжийн асуудал гэдэг нь нэлээн subjective буюу хувь хүн дээр тулгуурласан, 2014 оны арга

аргачлалаар яаж нөгөө олонлогоо тооцож гаргасан юм бэ, simple size энэ арга аргачлал нь ямар юм бэ, энийгээ яаж засаж янзлах гэж байгаа юм бэ, бодитой өөрчлөлт хийх гэж байгаа юу, үгүй юү гэдэг дээр бас хариулт авах сонирхолтой байна. Баярлалаа.

М.Ганхүлэг: Нэлээн хэдэн тодорхой асуултуудыг асууж байна. Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан сайд хариулна.

Т.Мөнхсайхан: Энэ банкны асуудал бол ер нь өмнө нь нийгмийн даатгалын сан, эрүүл мэндийн даатгалын сан 2 цуг байх үед үүссэн энэ авлагын асуудлууд юм байгаа юм. Тэгээд эндээс ер нь хураагдсан эд хөрөнгүүдээс бас тодорхой хэмжээг нь ЭМД-ын сан руу шилжүүлж авах энэ асуудлууд хийгдээд явчихсан байж байгаа. Одоо үлдэгдэл нь 130 орчим тэрбум төгрөг байгаа. Эндээс бас шилжүүлж авч, ашиглах боломжтой өрийг барагдуулах боломжтой энэ үл хөдлөхүүдийг шилжүүлж авах асуудал үргэлжлэн яригдаад, үнэлгээнүүд нь хийгдээд явж байгаа юм.

Ирэх оны санхүүжилтийн хувьд бид нар ер нь нэлээн зохицуулалтуудыг хийе. Даатгалынхаа сангийнхаа оновчтой зарцуулалт, хамтын төлбөр, эрүүл мэндийн байгууллагын үр өгөөжтэй санхүүжилт гэх мэтчилэн ийм томоохон өөрчлөлтүүдээ бид нар зөв оновчтой хийж чадвал эргээд энэ цалин мөнгөний асуудалд орохгүйгээр байх боломж юу байна гэдэг тал дээр л ажиллаж байгаа юм. Яг үнэхээр цалин мөнгөний асуудалд орохгүйгээр Эрүүл мэндийн даатгалын сан эрүүл мэндийн салбарын санхүүжилттэй тийм түвшинд хүргэе гэх юм бол ЗГ-ын нийт санхүүжилтийн 12 хувьд, ДНБ-ий 6 хувьд хүргэж байж л бид нар энэ санхүүжилтийн асуудлаас сална. Тэгээгүй тохиолдолд өнөөдрийн түвшинд бид нар бол ямар нэгэн байдлаар тусламж, үйлчилгээ дээр хязгаарлалт тавих, тоо тавих, даатгалын сангийн санхүүжилтийг хязгаарлахаас өөр

аргагүй нөхцөл байдалтай л байгаа. Тэр асуудлууд маань ирэх онд үргэлжилж л таарна. Гэхдээ бид нар энэ зарцуулалтуудаа зөв оновчтой болгоё гэдэг энэ бодлого барьж байгаа.

Эмнэлгээр үйлчлүүлж байгаа иргэдийн сэтгэл ханамжийн асуудал бол төдийлөн тийм өндөр биш байгаа. Энийг бол бүх л хүмүүс мэдэж байгаа. Энийг бид нар дээшлүүлэх талаар нэлээн цогц бодлогууд хийж, хэрэгжүүлж байгаа юм. Яг үйлчлүүлж байгаа иргэд маань сэтгэл ханамжийнхаа судалгаанд хамрагдах энэ асуултдаа хариулаад явчих энэ боломжийг бүрдүүлэх энэ бар кодыг бид нар ер нь бүхий л түвшинд нь байрлуулъя. Гэхдээ хаана байрлаж байгаагаасаа хамаараад эргээд энэ дээр асуулт асуумжийг нь бид нар нэлээн олон улсын түвшинд бодитой үнэлгээ гаргачих хэмжээнд тавигдах ёстой юм байна гээд энэ дээр цогц бодлого, арга хэмжээнүүд авч байна. Тэр шалгуур үзүүлэлтийн талаар манай Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Оюунцэцэг дарга хариулчих.

М.Ганхүлэг: Тийшээ өгч болох болов уу микрофоныг нь. Оюунцэцэг дарга та 7 номер луу очоорой. Бусад ажлын хэсгийн гишүүд маань энэ дугаартай микрофонууд дээр очиж сууж хариулах юм байгаа шүү. Очоод суухаар нь цагийг нь эхлүүлээрэй. 7 номерын микрофоныг өгье.

П.Оюунцэцэг: Ганмаа гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө энэ дээр 3 урьдчилан сэргийлэх үзлэгийн дүнг авсан байгаа. Энэ дээр артерийн даралт ихсэх, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэг ДЭМБ-аас улс орнуудад эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгийн ерөнхий нөгөө үзүүлэлтийг хамруулж үздэг үзүүлэлт учраас энд чихрийн шижин, артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэгийг хамруулж байгаа. Энэ маань өөрөө цаашидаа Тогтвортой хөгжлийн зорилтын нөгөө 30-аас 70 насны хүн амын дундах зурх судас, чихрийн шижингийн нас баралтын

түвшнийг тодорхойлоход бас түлхэц үзүүлэлт гэдэг утгаараа энд орж ирж байгаа.

Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалт бол харьцангуй урьдчилан сэргийлэх боломжтой өвчлөлтүүдийн хүрээнд авч үзсэн байгаа. Энэ удаагийн шалгуур үзүүлэлт юун дээр Алсын хараа 2050 дээр бол 2050 онд хүрэх зорилт, 30 онд хүрэх зорилт дээр тавьсан. 2023 оны энэ үзүүлэлтийн суурь үзүүлэлтийг тавихдаа.../минут дуусав/

М.Ганхүлэг: Гүйцээж хариулъя.

П.Оюунцэцэг: Энэ үзүүлэлтийг тавихдаа ер нь сүүлийн 5 жилийн дунджаас бид нар харж байгаад бас үзүүлэлтээ тодорхойлж тавьсан байгаа.

М.Ганхүлэг: Ганмаа гишүүн тодруулна.

Д.Ганмаа: Тодруулъя. Тэр шалгуур үзүүлэлт чинь Алсын хараа дээр 2025 2050 хүртэл байгаа шүү дээ 3 удаа. 2025 оных нь бол эхний 1 дүгээр үе шат. Тэгээд 1 дүгээр үе шатынхаа шалгуур үзүүлэлттэй таарахгүй байна гэдэг асуудлыг асууж байгаа. Яагаад таарахгүй байгаа юм бэ, яагаад багасгаж оруулж ирж байгаа юм бэ? Үндэслэл нь юу юм бэ? Гарч байгаа асуудлууд байна уу?

2 дугаарт энэ шалгуур үзүүлэлтүүдийн чинь тоо их бага байгаа байхгүй юу 0,2 0,3 гээд. Тэгээд мөнгө тодорхой хэмжээний мөнгө зарцуулаад, тэгээд ийм бага хувиар тавиад байгаа шалтаг шалтгаан нь яагаад ийм байгаад байгаа юм бэ?

М.Ганхүлэг: Хэн хариулах вэ? 7 номер.

П.Оюунцэцэг: Түрүүн хэлсэн. Тэр нөгөө эрт илрүүлэг үзлэгүүдийн Эдийн засаг, хөгжлийн яамнаас хөгжлийн

бодлого, төлөвлөлтийн шалгуур үзүүлэлтийг боловсруулах аргачлалын дагуу сүүлийн 5-аас, 5 жилийн дундаж дээр бид нар үндэслээд энэ үзүүлэлтээ жосоохон бууруулж оруулж ирсэн байгаа.

М.Ганхүлэг: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асуулна.

Ц.Идэрбат: Ерөнхийдөө энэ ЭМД, нийгмийн даатгалын сан дээр үүсээд байгаа нөхцөл байдал юмнуудаа бол энэ сайд нар бас нэлээн анхаараад, хууль хяналтын байгууллага руу шилжүүлээд ингээд явж байгаа юм байна. Ер нь тэгээд яриад удлаа шүү дээ. Эрүүл мэндийн байгууллага дээр машин байхгүй, тоног төхөөрөмж байхгүй хэр нь даатгалын сан дээр алдчихсан мөнгийг нь харахаар сонсохоор харамсмаар дүн л байдаг юм шүү дээ. Тэгээд орон нутагт очоод л тийм ч багаж байхгүй, ийм ч машин байхгүй гэдэг байсан. Тэгээд энийг ингээд харьцуулж хараад орон нутгийн энэ салбарын байгууллагынхан бол маш ихээр эмзэглэдэг байсан л даа. Тэгээд энэ дээр бас ингээд зоригтой дорвитой арга хэмжээ авч байгаад би бас талархалтай хандаж байгаа 2 сайдад бол.

Эрүүл мэндийн салбар дээр ингээд ирэх жил 45 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж юмнууд байгаа юм байна. Тэгээд би өнгөрсөн парламентын үед бас энэ эмч, бага эмч нарыг сургах, дадлагажуулах энэ орчин үеийн өндөр өртөгтэй энэ багаж тоног төхөөрөмжүүд дээр ажиллах энэ бололцоонуудыг бас гадагш нь явуулж сургах асуудал дээр бас яам нэлээн анхаараач гэдэг зүйлийг хэлж байсан юм байгаа юм. Тэгэхээр энэ дээр бас ЭМЯ-ны бодлого бас ямархуу байгаа вэ гэдэг дээр.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас ажиллах хүчний хомсдолд орчихсон байгаа нь үнэн. Манай энэ ААН-үүдийн гол толгойны өвчнүүдийн нэг бол энэ татвар, НДШ, 3-д нь бол гол юм бол энэ ажиллах хүчний хомсдол гэдэг дээр орчихсон гэдэг бол туйлын үнэн юм билээ.

Үнэхээр бас юм хийнэ гэхийн оронд бараг тэр мөнгөө банканд хийгээд сууж байх нь хамаагүй илүү байна. Нөгөө хүнээр хүн хийх хэцүү гэдэг шиг, хүнээр ажил хийлгэх бүр хэцүү болчихоод байна гээд ингээд яриад байгаа юм. Тэгэхээр энэ гаднаас ажиллах хүч оруулж ирэх тал дээр энэ яамны зүгээс өнгөрсөн парламентын хувьд тэр ажиллах хөлсний тэр хураамжийг нь, квотыг нь бас нэлээн уян зөөлөн болгосон. Энэ дээр ямар ахиц дэвшилүүд бас гарч байгаа вэ гэдэг дээр би асууж тодруулъя гэж ингэж бодож байна.

Ажиллах хүчний хомсдолд орсон дараагийн бас нэг гол хүчин зүйл бол энэ ажлын хөлсийг нь өгдөггүй, хар үгээр яривал хулхиддаг ийм байдал бол орон нутгуудад бол хавтгай байдаг юм шүү. 10 хэдэн сая, 20 хэдэн сая төгрөгийг нь өгөөгүй алга болдог. Тэгээд энэ дээр бол ердөө тэгээд иргэний журмаар яваарай чи шүүхдээ хандаарай гэдэг. Тэндээс ирж энэ Улаанбаатарт байгаа ААН-тэй шүүхдэлцэх хүмүүс ховор байдаг учраас, байхгүй байдаг учраас орон нутагт нэг тийм хандлага гараад байдаг юм. Тэгээд шүүхэд хандъя гэхээр аль нэг дүүрэг дээр ирэх болдог. Тэр чинь ямархуу их асуудал араас нь дагуулах билээ. Энэ дээр бол бас яамны зүгээс энэ Хууль зүйн яамтай бас нэлээн уялдаа холбоотой ажиллах ийм зүйл бас нэг хүчин зүйл нь байдаг юм болов уу гэж ингэж бас хардаг юм. Тэр дээр ер нь ямархуу чиг бодлоготой байгаа вэ?

3-д энд хугацаагүй болох гээд байна. Хүүхдийн мөнгөний асуудал. Өнгөрсөн парламентын үед бас би хэлж л байсан. Өнөөдөр хүүхдийн мөнгө гээд бид нар 1,5, 6 их наяд 4, 5 том үйлдвэр байгуулах мөнгөө өгч байгаа юм хүүхдүүдтэй. Гэхдээ яг хүүхдэдээ очиж байгаа юу, үгүй юү гэдэг.../минут дуусав/

М.Ганхүлэг: Нэмэлт авах уу? Нэмэлт 1 минут өгье. Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Яг хүүхдэд зориулагдаж байна уу, үгүй юү гэдэг дээр

та бид бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Хүүхдэд очихгүй байгаа. Энэ хүүхдийн хөгжлийн асуудлууд, энэ хүүхэд хамгааллын асуудлууд зөндөө юмнууд дээр энэ бол ингээд хаягдаад байгаа. Тэгэхээр яг энэ хүүхдэд олгож байгаа энэ мөнгө яг хүүхэд өөрийнхөө хөгжилд зарцуулдаг болгох тийм шинэчлэлийн асуудлууд байгаа юу? Тэр дугуйлан, секцэд явдаг, өөрийн хэрэгтэй байгаа ном, дэвтрээ авдаг ийм юм руугаа оруулбал бид хүүхэд рүүгээ өгч байгаа гэдэг энэ агуулга маань өөрөө үр дүнтэй болох болов уу гэж би боддог юм. Тэгэхээр энэ дээр салбарын яамны зүгээс бас ямар бодлого байдаг юм бол? Тэгэхээр өнөөдөр бол хүүхдийн мөнгө, хүүхдийн мөнгө буусны ар дээр ямар юм илүү борлогдож байна эд нар гээд бас олон л зүйлүүд яригддаг шүү дээ. Тэгэхээр хэдүүлээ энэ дээр бол бас энэ Их Хурал гэдэг чинь дандаа сайн сайхан биш, ирээдүйг харсан зүйлийг ярих ёстой газар гэж ингэж бодож байгаа учраас би энэ хүүхдийн мөнгөний асуудлыг бас ярьж байгаа юм.

М.Ганхүлэг: Тодорхой асуултуудад хариулт авъя. Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан сайд эхэлье. Боловсон хүчинтэй холбогдолтой, мэргэжлийн боловсон хүчинтэй холбогдолтой асуудлаар.

Т.Мөнхсайхан: Бид нар ер нь энэ боловсон хүчнүүдээ гадагшаа явж сургах дадлагажуулах асуудал дээр нэлээн онцгой анхаарал хандуулаад энэ гадаад харилцааг нэлээн өргөжүүлж байгаа. Тэгээд Улаанбаатар, орон нутаг гэлтгүй гадагшаа явж сурах мэдлэгээ дээшлүүлэх энэ боломжууд бол асар ихээр нэмэгдэж байгаа. Ялангуяа манай улсын хувьд бол 10 мянган хүнд ноогдох эмчийнхээ тоогоор бол дэлхийд ордог. Гэсэн хэдий боловч орон нутагтаа эмч мэргэжилтнийх нь дутагдал байгаа учраас бид нар ер нь цаашидаа орон нутаг руу чиглэсэн хүний нөөцийн бодлогоо яаж хэрэгжүүлэх вэ гэдэг дээр цогц бодлого, арга хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа.

Тэгээд гадагшаа явж байгаа сургалтууд дээрээ эхнээсээ бид нар орон нутгаасаа хүмүүсээ авч явуулъя гэдэг хүсэлтүүдийг явуулсан. Жишээ нь гэхэд энэ жилд Харвард руу ингээд 20 хүн удирдлагын чиглэлээр сурна, орон нутгаас хүмүүс оруулъя ингээд саналаа ирүүлээч гэхээр хэл усны мэдлэг нь тэнцдэг зүйлүүд ховор болчихоод байна. Вашингтоны их сургууль руу дата, биг дата дээр ажилладаг 30 дата аналитуудыг 10 хүнийг явуулж сургая, ирэх оны эхний улиралд явуулна. Ингээд орон нутгаас явах хүн байна уу, хэлний түвшин мэдлэг хүрэх хүн байна уу гэхээр энэ түвшинд хүрэх хүн олдохгүй байх жишээний. Ингээд бид нар бол орон нутгийнхныгаа аль болох мэдлэг чадварыг нь сайжруулъя гэдэг энэ бодлогоо хэрэгжүүлж байна.

Тэгэхээр бид нар цаашид энэ орон нутгийнхныхаа ер нь энэ хэлний мэдлэгийг сайжруулах энэ бодлогыг эхний ээлжид авч хэрэгжүүлье. Тэгэх юм бол цаашидаа гаднын аль ч улсад очоод мэдлэг мэргэжлээ сайжруулчих энэ боломж бололцоогоор нь хангах боломжууд бол жил ирэх тусам нэмэгдэж байна. Ирэх жилийн хувьд бол илүү маш их нэмэгдэж байна. Тэгэхээр энэ хэлний мэдлэгийг нь сайжруулах энэ бодлогыг хийж хэрэгжүүлье. Энэ дээр бас орон нутгийн удирдлагууд бас анхаарч ажиллаасай гэж бодож байгаа юм. Тэгж чадах юм бол бид нар орон нутгийнхныгаа чадавхжуулах, энэ төвлөрлийг сааруулах, тухайн амьдарч байгаа орон нутагтаа тусламж, үйлчилгээгээ авах энэ боломжийг бүрдүүлнэ гэдэг манай салбарын бас гол барьж байгаа бодлого байгаа. Энэтэй энэ хүний нөөцийн бодлого маань 100 хувь уялдаж байгаа учраас цаашидаа хэлний мэдлэг дээр нь анхаараад, ингээд хэлний мэдлэг нь сайжирсан тохиолдолд аль ч улс руу явуулаад мэдлэг мэргэжлийг нь сайжруулчих боломжуудыг 100 хувь хангаж өгнө гэж хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

М.Ганхүлэг: Энх-Амгалан сайдад 3 минутаар нөгөө цагийг нь өгье. Ажиллах хүчний асуудал, хүүхдийн мөнгө.

Л.Энх-Амгалан: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Мааш чухал асуудал хөнжилд хөндлөө. Ажиллах хүчний хомсдолын асуудал. Энэ үнэхээр Монгол Улсад нүүрлэсэн хамгийн том асуудал болж байна. Тэгэхээр 1 удаагийн тийм гал унтраах арга хэмжээг би бол авч болохгүй л гэж ойлгож байгаа. Энэ бол бас эргээд бид нар хөдөлмөрийн зах зээлийнхээ эрэлт, нийлүүлэлт асуудал дээр их зөв оношилгоо хийж хөдлөх ёстой гэж би ойлгож байгаа юм. Тэрнээс биш ажиллах хүчин хомсдолоо гээд энэ жилдээ, 2 жилдээ гаднаас оруулж ирээд ингээд ажиллах хүчнийг нь өгчихье гэж ингэж ийм богино зайны улс төр, богино зайны бодлого бол би хийж болохгүй гэж бодож байгаа юм.

Тэгэхээр ямар ч байсан нэгэнт ажиллах хүчний хомсдол одоогийн байдлаар бол 52 мянга гэж бид нар зарлаж байгаа шүү дээ. 52 мянган хүний ажлын байр дээр ажиллах хүн олдохгүй байна гэж. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд мэдээж Булгантуяа сайд бас сайд байхдаа тодорхой бодлогын арга хэмжээнүүд бас авч эхэлсэн. Тодорхой салбаруудын нийт эдийн засгийн Монгол Улс чинь эдийн засгийн 21 салбартай юм байна лээ. Тэгээд 21 салбарын 16 салбар дээр ямар ч байсан квотгүй болгоод, тэгээд тэр авдаг төлбөрийнх нь хэмжээг 50 хувь хүртэл хувь бууруулсан. Гэхдээ энэ гаргасан ЗГ-ын шийдвэр бас бодитой хэрэгжиж чадаагүй яг үнэнийг хэлэхэд, бодитой хэрэгжиж чадаагүй.

Тэгэхээр цаашидаа бид нар энэ Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульдаа бид нар өөрчлөлт оруулмаар юм байна лээ Идэрбат гишүүнээ. Хууль дээр бид нар ямар өөрчлөлт оруулах гээд байна вэ гэхээр 1 дүгээрт ерөөсөө энэ ажиллах хүчний квот, энэ төлбөрийн хэмжээний асуудлыг ЗГ өөрөө дотроо аль, аль салбараар нь

шийдээд явах ёстой юм бэ гэдэг шийдвэрээ ЗГ эрхээ 1 дүгээрт авах асуудал байгаа юм.

2 дугаар асуудал энэ гаднаас ажиллах хүчин авахад нөгөө авдаг зөвшөөрлүүдийн асуудлууд дээр мааш их хүнд суртлын бид нар хуулиараа хийгээд өгчихсөн юм байна. Бараг үндсэндээ одоогийн энэ хуулиар авахад гаднаас ажиллах хүчин авах зөвшөөрлүүдийг холбогдох яамнуудаас, манай агентлагуудаас авахад бол бүтэн 2 сар ийм хүнд суртлын процессыг бид нар хуульчлаад өгчихсөн байгаа байхгүй юу. Хуульчлаад өгчихсөн. Тийм учраас энэ хууль хуульчилж өгсөн энэ хүнд суртлын процессуудаа бид нар арилгах ийм зайлшгүй шаардлага байна гэж харж байгаа юм.

3 дахь асуудал одоо бид нар цаашидаа өндөр бүтээмжтэй, өндөр цалинтай энэ эдийн засгийнхаа салбаруудыг бид нар хамгаалах ёстой. Жишээ нь Оюу толгой дээр 100 хувь Монгол хүн л ажиллах ёстой. Гадаадын томоохон төсөл хөтөлбөрүүд дээр тэр ажиллах хүчнийх нь 90 хувь хүртэл Монголчууд ажиллах ёстой. Тийм учраас нөгөө чоно борооноор гэдэг шиг өндөр цалинтай, өндөр бүтээмжтэй ажлууд дээр гаднынхан орж ирэх энэ асуудлыг бол бид нар хатуу хориглох ёстой гэж бид нар ойлгож байгаа. Хамгийн гол нь бага бүтээмжтэй, бага цалинтай Монголчууд сонирхож ажиллаж чадахгүй байгаа энэ ресторан, үйлчилгээний газар чинь мөн ажилладаг хүнгүй болчихоод байна гэж олон жижиг, дунд бизнесийнхэн гомдол хэлж байна шүү дээ. Тэгэхээр тэр асуудал дээр бид нар их тийм зөв бодлого, тохируулга хийх ийм зайлшгүй шаардлага байгаа байна уу гэж 1 дүгээрт харж байгаа.

2 дугаар асуудал та нөгөө хөдөлмөрийн мөлжлөгийн асуудал ярьж байх шиг байна. Энэ жижиг, дунд компаниуд, жижиг, дунд хэмжээний компаниуд дээр бас ийм асуудал хүнийг

хөлсөөр авч ажиллуулчихаад цалин хөлсийг нь өгдөггүй нэг ийм.../минут дуусав/

М.Ганхүлэг: Гүйцээж хариулъя.

Л.Энх-Амгалан: Энэ нэг ийм нийтлэг гэх үү нэг ийм асуудал байгаа юм. Тэгэхдээ энийг бас яг хяналт тавих, шийдэх ёстой байгууллага нь бол мэдээж манай яам. Тийм учраас манай яаман дээр нөгөө мэргэжлийн хяналтын хөдөлмөрийн хяналт нь ирсэн учраас хяналтын байцаагчдаараа дамжиж бид нар энэ асуудлуудыг шийдэх ёстой. Нөгөө өөр нэг ажилладаг механизм энэ хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх комисс. Бүх аймаг, дүүргүүд дээр байгаа. Тийм учраас илүү шүүх гэхээсээ илүү хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх энэ комисстоо өргөдөл, гомдлуудаа өгөөд ингэх юм тодорхой цаг хугацаа хэмнэсэн ийм шийдлүүд байх болов уу гэж харж байгаа.

3 дугаар асуудал хүүхдийн мөнгөний асуудал байгаа. Хүүхдийн мөнгөн дээр энэ Их Хурал л тодорхой шийдэл гарах ёстой л гэж би ойлгож байгаа. Маш их эмзэг асуудал. Тийм учраас 25 онд бид нар хүүхдийн мөнгө бүгдэд нь өгнө. Цаашидаа бид нар энэ хүүхдийн мөнгөнд зарж байгаа 1,5 их наядыг яаж бодлого болгох юм бэ гэдэг асуудал дээр Их Хурал дээр л тодорхой шийдэл гаргах нь зөв болов уу гэж бас харж байгаа.

М.Ганхүлэг: Идэрбат гишүүн тодруулна.

Ц.Идэрбат: Өнгөрсөн парламентаар Хүүхэд хамгааллын хууль батлагдсан. Хүүхэд хамгааллын энэ тогтолцоог бид нэг кэйс гарсны ар дээр л нийгмээрээ ярьдаг, долоо хоноод л мартдаг байж болохгүй. Тэгээд Хүүхэд хамгааллын энэ хууль дээр бас нэлээдгүй орон тоотой, санхүүтэй холбоотой, тэр дундаа улсын төсөв болон орон нутгийн төсөвтэй холбоотой нэлээн зүйлүүд байгаа. Орон нутгийн удирдлагууд шинээр

сонгогдож байна. Энэ хүүхэд хамгааллын зардал энэ бүх зардлууд бол орон нутгийн төсвөөс гарах эрх зүйн орчныг нь бол өнгөрсөн парламент дээр тэр хууль дээр сайн нээж өгсөн. Энэ дээр яамныхан маань орон нутгийн удирдлагуудтай энэ шинэ төсөв, төлөвлөгөө яригдах үед хэрхэн хамтарч ажиллах ийм зүйлүүд бас хийж байгаа вэ гэдэг дээр бас би тодруулъя. Дээрээс нь энэ сумуудад ажиллах хүүхэд хамгааллын асуудал хариуцсан тэр мэргэжилтний орон тооны асуудал энэ 2025 оны төсөв дээр хэрхэн тусгагдсан байгаа вэ гэдэг дээр бас би тодруулга авъя гэж бодож байна.

М.Ганхүлэг: Энх-Амгалан сайдын микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Юун түрүүнд бас бид нар Идэрбат гишүүндээ талархах ёстой. Юунд талархах ёстой вэ гэхээр Идэрбат гишүүн маань өнгөрсөн парламентын үед хамгийн чухал хуулийг ажлын хэсгийг ахалж энэ Хүүхэд хамгааллын тухай хуулийг ахалж, энэ хуулийг Улсын Их Хурлаар батлуулсанд би салбарын сайдын хувьд гүн талархал илэрхийлэх ёстой.

Бид нарын үүрэг бол таны батлуулсан энэ хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах ёстой. Тийм учраас бид нар ямар ч байсан энэ 25 оны өнөөдөр ингэж хэлэлцэгдэж байгаа энэ төсөв дээр анхан шатан дээр 590, хороодод бол 337 буюу нийт 927 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллах ийм шаардлагатай байгаа. Ингээд энэ 927 нийгмийн ажилтны цалингийн санд 24,7 тэрбум төгрөг, НДШ-д 3,3 тэрбум гээд нийт 28 тэрбум төгрөгийг бид нар гэрээгээр гүйцэтгүүлэх төсөв 25 хоног төсөв дээр суусан байгаа. 2 дахь.../минут дуусав/

М.Ганхүлэг: Гүйцээж хариулъя.

Л.Энх-Амгалан: 2 дахь асуудал салбарын сайд аймгийн Засаг дарга нартай гэрээ хийдэг. Одоо ингээд энэ

аймгийн сая орон нутгийн сонгууль болж дууслаа. Тийм учраас бол удахгүй аймгийн Засаг дарга нар томилогдоод, Монгол Улсын ЗГ-тай, салбарын сайд нартай бол Аймгийн Засаг дарга нар гэрээ хийдэг. Ингээд энэ гэрээ хийх 25 оны Аймгийн Засаг даргатай хийх гэрээ дээр бид нар энэ Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орон нутгийн оролцох оролцоонууд дээр нэлээн үүрэгжүүлсэн ийм гэрээ хийе гэж бас төлөвлөж байгаа.

М.Ганхүлэг: Баярлалаа. Эхний асуудалтай холбогдолтой, хэлэлцэх асуудалтай холбогдолтой гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Нэлээн бас нээлттэйгээр тодруулгуудыг их сайн өгч мөн бас асуултад гэсэн цаг хугацаанууд нэлээн өгч ярилцлаа. Асуулт асууж, хариулт авч дууслаа. Ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтой 2 асуудлаар зарчмын зөрүүтэй санал гаргасан байгаа гишүүд маань. Санал хураалтыг явуулж эхлүүлье. Дэгийн тухай хуулийн 39.14-д Байнгын хорооны гишүүд ажлын 2-оос доошгүй хоногийн өмнө өөрсдийнхөө зарчмын зөрүүтэй саналыг ирүүлнэ гэсэн ийм Дэгийн тухай хууль дээр заалттай байгаа. Үүний хүрээнд 2 санал ирсэн байгаа. Энэ 2 саналаар бүгдээрээ санал хураана. Тухайн асуудлыг оруулж ирсэн гишүүн маань бас өөрсдөө тодруулга бас хэлэх боломжтой. Тэгэхээр асуудлаа яг танилцуулахаар гишүүд маань өөрсдөө тодруулгаа хэлээд ингээд явъя гэж бодож байна.

Эхний зарчмын зөрүүтэй санал. Үүрийнтуяа гишүүн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцын урсгал зардалд багтах Нийгмийн халамжийн сангийн хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний санхүүжилтэд тусгагдсан 21,381.2 сая төгрөгийг 300.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр “Нийгмийн даатгалын

ерөнхий газрын үйл ажиллагааны зардлын өмгөөлөл хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс зориулалтад нэмж тусгах гэдэг саналыг оруулсан байгаа. Энэхүү саналтай холбогдолтой тайлбар хэлэх үү? Үүрийнтуяа гишүүн тайлбар хэлнэ.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Нийгмийн даатгалын сангийн тодорхой эх үүсвэрүүд өнөөдөр бас 2 ч банкны баталгаагүй найдваргүй авлага хэмжээнд оччихсон. Өнөөдөр нийгмийн даатгалын сангийн энэ хөрөнгөнөөс зарлага гаргах боломжгүй хэмжээнд оччихсон ийм өглөг, авлага үүсээж байгаа асуудлууд нэлээдгүй урт хугацаанд яригдаж байгаа. Гэхдээ өнөөдрийг хүртэл НДЕГ-аас ямар нэгэн байдлаар хууль хяналтын байгууллагад хандсан зүйл, шүүхэд өгсөн асуудал ерөөсөө байхгүй байгаад байгаа. Энэ сангийн мөнгийг бид нар олж авахын тулд энэ дампуурлаа зарлаагүй байгаа ч гэлээ гэсэн энэ банкнуудтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд хууль, эрх зүйн хүрээнд тодорхой хэмжээнд өмгөөллийн үйлчилгээ авч ажиллах нь бол зүйтэй гэж миний хувьд үзэж байгаа юм.

Яагаад гэхээр өнөөдөр бол энэ Банкны дампуурлын тухай хуулиар хамгийн түрүүнд 1 дүгээрт хувь хүний мөнгийг өгдөг, дараа нь төрийн мөнгийг өгдөг. Өнөөдөр яагаад нийгмийн даатгалын сангийн мөнгийг өнөөдрийг хүртэл өгөөгүй байна вэ гэхээр төрийн мөнгө гэж үзээд байгаа юм. Гэтэл энэ өөрөө хувь хүний мөнгө. Хүмүүсийн мөнгө нэгдээд энэ санд байришиж байгаа юм. Тийм учраас энэ мөнгөн хөрөнгийг олж авахын тулд тодорхой хэмжээнд хуулийн үйлчилгээний зардал гаргаж ажиллах нь зүйтэй байгаа. Би энэ талаар бас ЭМЯ, Эрүүл мэндийн сайдтай юу нийгмийн даатгалын асуудлаа яг энэ сангийн асуудлыг хариуцаж байгаа Энх-Амгалан сайдтай Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай бас ярьж зөвшилцсөн.

Тэгээд танайх бас тодорхой эх үүсвэрээ энийг зохицуулаад энэ хуулийн

үйлчилгээндээ зардал гаргаад, энэ хуулийнхаа асуудлыг эцэслэж яваач гэдэг энэ асуудлыг ярихад бол энэ зардлынхаа саналыг бол гаргаж ирсэн юм байгаа юм. Тэгээд энэ нийгмийн даатгалын сангийн хүнс тэжээлийн санд байгаа 21 тэрбум төгрөгийг 300 саяар бууруулах асуудал бол ямар нэгэн байдлаар хүнд хүрэх асуудал хасагдах тухай байхгүй. Эндээс бас 300 сая төгрөгийг зарцуулаад бусад үйлчилгээгээ бүрэн үзүүлээд явах боломжтой гэж яам бас үзэж байгаа. Тийм учраас энэ саналыг оруулсан юм байгаа юм. Та бүхэн бас дэмжиж өгөхийг хүсье.

М.Ганхүлэг: Үүрийнтуяа гишүүн саналын үндэслэлээ танилцууллаа. Дэгийн тухай хууль дээрээ бол ЗГ-ын сайд нар нэмэлт тайлбар хэлэх боломжтой. Энх-Амгалан сайд тайлбар хэлэх үү? Микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Би Үүрийнтуяа гишүүндээ талархаж байгаа. Тэгээд манай Байнгын хорооны гишүүд бас дэмжинэ гэж ойлгож байгаа. Яагаад гэвэл өнгөрсөн долоо хоногийн нэг дэх өдөр би Байнгын хорооныхоо гишүүдтэй уулзаж, энэ үүссэн эрсдэлийн, энэ эрсдэлд үүссэн авлагыг барагдуулах ийм, ийм хэлбэрүүд байна гэдэг хувилбаруудыг бас танилцуулсан. Тийм учраас бас ойлголт нэгтэй байгаа болов уу гэж бодож байна.

Тэгэхгүйгээр хууль, эрх зүйн зөвлөгөө мэргэжсэн хуульчид, өмгөөлөгчдийг авахгүйгээр бид нар 160 тэрбум төгрөгийн авлагыг ингээд, ингээд өдөр өнгөрөөд, тэгээд тэр нөгөө банкнуудынх нь ав гэсэн үнэтэй, үнэгүй үл хөдлөхийг авах маягаар ийм байдлаар би энэ татвар төлөгчдийн тэр тусмаа НДШ төлөгчдийг бол би хохироож ерөөсөө болохгүй гэж ойлгож байгаа. Тийм учраас энэ бол юуны асуудал.

Нөгөө талаасаа ер нь цаашидаа энэ хөдөлмөр эрхэлж байгаа, хөдөлмөрийн чадвартай нөхдүүдэд энэ хүнсний талон өгдөг, хүнсний талоноор амьдардаг ийм

байж болохгүй нөхдүүдээ. Ажил хөдөлмөр эрхлэх ёстой. Тийм учраас энэ 330 сумд их сайн хандлагууд гарч ирж байна. Өнөөдөр 100 орчим сумууд маань хүнсний талоноосоо татгалзаж байгаа ийм сайн санал санаачилгууд гаргаж ирж байгаа. Тийм учраас цаашидаа энэ хүнсний талоноо авахаа больсон ийм сумуудыг бид нар Хөдөлмөр эрхлэлтийн сангаас, Жижиг, дунд үйлдвэрийн сангаасаа дэмжээд явах дээр ажлын байруудыг нь тухайн орон нутагт нь, хороодод нь бий болгох энэ санал санаачилгыг бид нар дэмжээд явна. Тийм учраас энэ 21 тэрбум төгрөгөөс хүнсний талоны 21 тэрбумаас 300 сая төгрөг хуульчдын зардлуудыг гаргахад ямар нэгэн асуудал гарахгүй. Ирэх жил энэ 21 тэрбумаас хэмнэлт гарна гэж би ойлгож байгаа.

М.Ганхүлэг: Жавхлан сайд нэмэлт тодруулга хэлье.

Б.Жавхлан: Үүрийнтуяа гишүүний тэр гарах зардлын эдийн засгийн ангилал агуулгыг нь бол дэмжиж байна, тэр зөв. Гэхдээ Байнгын хороон дээр гишүүдийн гаргаж байгаа энэ саналын зөрүүтэй томъёоллууд тэр харьяалагдах сайд нар өөрсдөө санал хэлэхдээ саяын томъёолол бол буруу шүү. Хэрвээ хэмнэлт гаргана гэдгээ мэдэж байсан, энэ 300 сая төгрөг хэрвээ илүү байгаагаа мэдэж байсан бол тэгвэл яах гэж ийм дүнг ЗГ дээр ирэх оны төсөв дээр суулгуулсан юм. Танайхаас ирүүлсэн яамны санал дотор чинь энэ чинь энэ дүнгээрээ явж байгаа.

Өөрөөр хэлбэл энэ дүнг ерөөсөө баталж өгөхгүй бол яамны төрийн үйл ажиллагаа доголдох нь байна гээд ирүүлсэн санал шүү дээ. Тэрнээсээ хоёрхон сарын дотор энэ чинь өөр юм ярьчихсан, хэмнэлт гаргана гээд ярьж байна гэдэг чинь юу гэсэн үг вэ.

Л.Энх-Амгалан: Гүйцэтгэлээр нь санхүүжүүлнэ гээд байна шүү дээ.

Б.Жавхлан: Үгүй ээ тэр хамаагүй. Та өргөн барьсан төслөө дүнгээр би

хэмнэлт гаргана гэдэг чинь юу гэсэн үг юм бэ? Та илүү мөнгө тэгвэл энд санал хүргүүлээд, энд батлуулчихсан явж байгаа юм байна шүү дээ. Тэгвэл өөр хэмнэлт гаргах юмнууд байвал бүгдийг нь хасах хэрэгтэй одоо энд ярьж байгаад.

М.Ганхүлэг: Зарчмын зөрүүтэй саналаар гишүүд болон ЗГ-ын гишүүд санал тайлбаруудаа хэллээ. Санал хураалтыг бүгдээрээ эхлүүлье. Үүрийнтуяа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг авъя, явъя. Манай гишүүд, Булгантуяа гишүүн хаанаас өгөх билээ? Би саналын томъёоллыг дахиад нэг уншаад өгчихье. Байхгүй шүү дээ. Та хэд маань саналаа л.

2025 оны төсвийн тухай хуулийн төслийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцын урсгал зардалд багтах Нийгмийн халамжийн сангийн хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний санхүүжилтэд тусгагдсан 21,381.2 сая төгрөгийг 300.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр “Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны зардлын өмгөөлөл хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс зориулалтад нэмж тусгах гэсэн энэ зарчмын зөрүүтэй саналаар дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалтыг түр юу яачихъя, санал хураалтыг түр цуцалъя. Болсон уу? Асуулт, санал авч болохгүй юм байна лээ шүү манайхан. Тийм учраас тэгээд дэгийнхээ дагуу л хэдүүлээ явъя. Санал 76,2 хувиар дэмжигдсэн байна. Би сая саналаа өгч амжсангүй шүү, дэмжих саналтайгаар протокол тэмдэглүүлье. Гишүүддээ баярлалаа.

2 дахь саналаар санал хураана. Улсын Их Хурлын гишүүн Ганмаа гишүүний зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2-р хавсралтын бүх төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 5 хувиар бууруулж, Эрүүл мэндийн сайдын багцын урсгал зардлыг

205.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал гаргасан байгаа. Санал гаргасан гишүүн үндэслэл тайлбар хэлэх үү? Ганмаа гишүүний микрофоныг өгье.

Б.Ганмаа: Улс орны хөгжилтэй холбоотой улсын төсвөөс хөрөнгө оруулалтын зардал багагүй мөнгө гаргаж байна. Энэ 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг харахад аудитын дүгнэлт дээр харахад Улсын Их Хурлаас хэлэлцсэн үед нэгдсэн төсвийн орлого нь давсан, зарлагын гүйцэтгэлийнх нь урсгал зардлыг 960 тэрбум, хөрөнгийн зардлыг 1 их наядаар дутуу зарцуулсан гэсэн гүйцэтгэл нь гарчихсан байна. Ингээд харахаар ингээд эрүүл мэндийн салбартаа зарцуулж байгаа мөнгө нь хангалтгүй, тэрнээс үүсэж байгаа асуудлууд дахин, дахин гарч ирж байна.

Иймд шаардлагагүй хөрөнгө оруулалт, урсгал зардлууд, эдийн засгийн өсөлтөд шууд нөлөөлөхгүй төсөл, хөтөлбөрүүд зэргийг нэмэгдүүлэхгүй байдлаар эрүүл мэндийн салбарт хуваарилах хэрэгтэй, зайлигүй шаардлагатай харагдаж байна. Сая ярьсан нөгөө ковидын үед ЗГ-ын төсвийн 12 хувьд хүрсэн энэ эрүүл мэндийн сангийн зарцуулалт нь. Одоо бол эргээд 4 функтээр буугаад, 30 гаруй хувиар дөнгөж явж байна. Иймд энэ урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал зэргээс би яг хаанаас нь танах юм 33 хуудас листүүдээс тусгай specific project-ийг үнэхээр ялгаж салгаж болсонгүй. Тэгэхээр нийт хөрөнгө оруулалтын зарцуулалтгүй эндээсээ 5 хувийг бууруулаад, энийг нь эрүүл мэндийн салбарт оруулах боломж байна уу, үгүй юу гэдэг энэ саналыг тавьж байгаа.

Үндсэндээ 100 төгрөг гарч байгаа бол 5 төгрөг болгоныг эрүүл мэндийн салбарт, хэрвээ энэ мөнгө орчих юм бол энэ цалин мөнгө, хангамж, эмийн асуудал гээд энэ сүүлийн үед бас телевизор, сошиалаар ч гэсэн яваад байгаа олон асуудлууд ишидэгдэх боломжтой

харагдаж байна. Яг энэ хөрөнгө оруулалтын санхүүжилтийн тэр дүн, тэгээд гүйцэтгэлийг 2023 оноор харахад ч тийм, 2024 оноор ч тэр ер нь гүйцэтгэлээрээ дандаа дутуу гараад байсан юм байна. Тэгэхээр эндээс ингэж бөөнд нь 5 хувиар авах ийм санал байна.

2 дугаарт нөгөө талаасаа гэж ярья. Нөгөө талаасаа эрүүл мэндийн салбарт хийж байгаа үйл ажиллагаануудын үр ашгийн судалгаанууд, хоорондын уялдаа холбоо, давхардлуудыг ил нээлттэй болгомоор байна. Жишээлбэл эрт илрүүлэг дээр ч юм уу. Тэрэн дээр n... гэж ярьдаг юм. Тэгэхдээ screening хийгээд байгаа тоонуудыг хэдэн хүн screen хийж байж, хэдэн хувийн ямар өвчлөлийг гаргаад, тэрийгээ яаж бууруулаад байгаа юм бэ? Тэр нь үнэхээр cost effective байна уу, үгүй юу гэдэг тэр тооцоо гэсэн үг. Энэ хэрвээ тэгээд тэрэн дээр чинь ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилчид тэрний цаг нар зөндөө бас олон тооцох юмнууд байгаа байхгүй юу.

Энэ дээрээсээ бид нар магадгүй илүү үр ашигтай зарцуулах датаг нь нээлттэй болгочих юм бол энэ дээр бид нар өөрсдөө ороод хараад, мэдээ мэдээллийг нь боловсруулаад, энэнийхээ үр дүнд яг тийм баталгаатай суурьтай ийм үйл ажиллагаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулж, эмнэлгийнхээ нийгмийн ч юм уу, юу байдаг юм асуудлуудыг шийдсэнээр, эргээд өөрөө эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар сайжрах, иргэдийн таатай орчин бүрдэх энэ боломжтой байгаа юм. Ингээд Жавхлан сайд мэдээж та энэ дээр юу яах байх, санал өгөх байх. Хэрвээ үнэхээр тэгж нийт хөрөнгөөсөө 5 хувь гэж байдаггүй бол өөр боломж байгаа юу, үгүй юу та хэлж зөвлөж өгвөл бас их баярлах болно. Тэгээд дэмжиж өгнө үү гэж хүсэж байна. Баярлалаа.

М.Ганхүлэг: Жавхлан сайд нэмэлт тайлбар өгөх үү. Байнгын хорооны, юу нэмэлт тайлбар саналгүй бол санал

хураалтыг явуулъя. Жавхлан сайд нэмэлт тайлбар хэлэхгүй гэж байх шиг байна тийм үү? Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Ганмаа гишүүний саналын зарчмын зөрүүтэй саналыг яах вэ ойлгож байна. Мэдээж эрүүл мэндийн салбар манай нийгмийн 3 том салбарын маань нэг нь. Эрүүл мэндийн салбар, боловсролын салбар, нийгмийн халамжийн, гэр бүлийн, нийгмийн халамжийн салбар маань нийлээд үндсэндээ манай урсгал зардал хөрөнгө оруулалтын ер нь 70 хувийг дангаараа эзэлдэг юм энэ 3 салбар. Тэгэхээр ямар чухал салбар вэ гэдэг нь ингээд харагдаж байна.

Монголын төр хэзээ ч эрүүл мэндийн салбараа орхихгүй байхгүй юу. Өнгөрсөн 4 жил бид нар маш хүнд үеийг эрүүл мэндийн салбар маань яаж ийж байгаад л төсөвтэйгөө бид ингээд л өнөөдрийг хүртэл аваад гараад ирлээ. Өнөөдрийн 160-аад тэрбум төгрөгийн ЭМД-ын сангийн алдагдал гэж байгаа маань бол тэр ковидын хүнд үеийг давсан энэ бол бодлогын зардал байсан. Бодлогын зардал байхгүй юу. Өнөөдрийн ингээд эдийн засаг, нийгмийн маань бас тогтвортой байдал, энэ 4 жилийг бас ингээд даваад ирсэн үр дүнгийн төлөө гарсан зардал гэж ойлгох хэрэгтэй. Тийм.

Тэгэхээр энэ бүх энэ одоо яах вэ ингээд энэ хүндрэлүүдийг аажим аажмаар бид нар даваад явна. Тэрнээс нэг мөр ингээд нэг цул пал гээд ингэх боломж бол төсөв дээр өөр дээр нь байхгүй. Тэгэхээр та энд тэрний төлөө гаргаж байгаа саналыг чинь би ойлгож байна. Тэгэхдээ нэг мөр ингээд нэг салбарын асуудлыг шийдэх гэж байна гээд бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардал, хөрөнгө оруулалт дээр ингэж болохгүй болов уу гэж бодож байна. Хөрөнгө оруулалтын 1 төгрөг, урсгал зардлын 1 төгрөг болгоны чинь цаана ард нь төсөл хөтөлбөр, үйл

ажиллагаа ЗГ-ын үйл ажиллагаа байж байдаг.

Төсвийн хамгийн 1 дүгээр зорилго төрийн үйл ажиллагааг тасалдуулахгүй санхүүжүүлэх үүрэгтэй юм. Тэрнээс хэдүүлээ ингээд хавтгайруулж ингэж нэг мөр ингээд хасах нь бол тийм оновчтой зүйл бас биш. Бид ковидын үед энэ геополитикийн хүндрэлтэй үед бид нар бол тодотголоор бол иймэрхүү арга хэмжээнүүд авч байсан л даа. Гэхдээ энэ удаа бол арай өөр байдлаар хэдүүлээ шийдэх нь зөв болов уу аль, аль талаа хараад, төсвийнхөө тогтвортой байдлыг хараад, эрүүл мэндийн салбараа хараад. Энэ чинь бусад өөр чухал зөндөө салбарууд байгаа. Хамгийн том төсөвтэй салбар маань нийгэм халамжийн салбар. Тэднийхээс 5 хувь гэхээр чинь энэ чинь бас бага тоо биш шүү. 3,7 их наядоос 5 хувь гэдэг чинь энэ чинь бараг 170, 80 тэрбум болоод явчихна. Тэгэхээр энэ талын юмнуудаа жоохон хараад, тэгээд яг тиймэрхүү саналуудаа яаж шийдэх вэ гэдгийгээ Ганмаа гишүүнээ төсвийн нөгөө ажлын хэсэг дээрээ яриад явбал тэнд гарц гаргалгаа юу байх нь вэ.

Одоо эндээс гаргасан зарчмын зөрүүтэй саналууд чинь хэрвээ дэмжигдвэл Төсвийн байнгын хороон дээр очиж давхар санал хураагдана. Тэгээд тэнд дэмжигдэхгүй бол тэгээд л зогсоно. Дэмжигдвэл ингээд цаашаа явна. Тэгэхээр яг төсвийн хувьд бол хэдүүлээ яг жигд бодлогуудаа харж явахгүй бол гэнэт нэг далайлтаар ингэх нь нэлээн тасалдал үүсэх эрсдэлтэй шүү. Өөр, өөр салбарууд дээр үйл ажиллагаанууд нь тасалдах эрсдэлтэй учраас та бас хараарай. Тэрнээс гишүүд л шийднэ шүү дээ. Би тэнд хөндлөнгөөс янз бүрийн.

М.Ганхүлэг: Асуудлын хувьд бол бас яах вэ бусад Байнгын хороодын асуудал руу шууд орж байгаа асуудал

болох юм байна. Тэгээд санал хураалгаж болно. Нэг бол та ерөнхий тайлбар мэдээллийг сонссон учраас татах боломжтой. Санал хураалгах уу? Санал хураалгачихъя? Ер нь яах вэ талуудын байр сууриудыг сонссон учраас саналаа ямар ч байсан хураалгаад явчихъя гэж бодож байна. Ганмаа гишүүн болж байна тийм ээ? Нэмэлт тайлбар бол өгөх хэрэггүй байх? Мэдээлэл авчихсан байгаа. Шинэ тутам бас гишүүд зарим зүйлүүдийг юу яах заавал ч үгүй тэр хуулийн заалт бусад зүйлүүдийг ойлгох шаардлагууд тулгамдаж байгаа, энийг бас харгалзан үзэх хэрэгтэй гэж бодож байна.

Ингээд Ганмаа гишүүний зарчмын зөрүүтэй саналаар санал хураалтыг эхлүүлье. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг эхлүүлье. 68,8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Ингээд өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх асуудал хэлэлцэгдэж дууслаа. Ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа. Санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд Булгантуяа гишүүн, Булгантуяа гишүүнээ танилцуулга хийе. Төсвийн байнгын хорооны гишүүн та байгаа юм байна.

14.20 цаг

Өнөөдрийн Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаан хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Гишүүдэд, ажлын хэсэгт баярлалаа. Ингээд 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

